



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БОЛОН НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БОЛОН НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-46

1. *“Хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн боловсролын өнөөгийн байдал, цаашдын асуудал” сэдвээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох* 4-46

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Нийгмийн бодлогын байнгын
хороодын 04 дүгээр сарын 12-ны өдөр /Лхагва гараг/-ийн хамтарсан хуралдааны
товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 63.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 50 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: С.Ганбаатар, Ж.Чинбүрэн, Ц.Идэрбат, Т.Аубакир, Э.Батиугар, Х.Ганхуяг, Н.Учрал;

Тасалсан: Ц.Сандаг-Очир.

Нэг. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын өнөөгийн байдал, цаашидын асуудал” сэдвээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Б.Гантулга, мөн яамны Боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын тэгш хамран сургалтын бодлогын удирдлага, зохицуулалтыг хариуцсан ахлах мэргэжилтэн А.Саруул, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, “Hand Pro” компанийн захирал Г.Оргилболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, мөн яамны Хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга М.Цогтбаатар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Нямсүрэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхбат, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Мандхай, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ч.Отгонцэцэг, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ч.Ариунболор, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Оюунчимэг, мөн яамны Эмнэлгийн тусламжийн газрын эмнэлгийн тусламжийн үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч Ө.Энхмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн,

референт Н.Монголмаа, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын өнөөгийн байдал, цаашдын асуудал” сэдвээр мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, “Hand Pro” компанийн захирал Г.Оргилболд нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Б.Баярсайхан, Ч.Ундрам, Д.Батлут, Ё.Баатарбилэг нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Оюунчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Л.Энх-Амгалан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын өнөөгийн байдал, цаашдын асуудал” сэдвээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 27 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 63.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
15 цаг 50 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Мөнхцэцэг: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны ирц 59.3 хувьтай байгаа учраас хуралдааныг эхэлье.

Хуралдаанд хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээллийг сонсохоор байгаа.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын өнөөгийн байдал, цаашдын асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан танилцуулна. Сайд танилцуулгаа хий.

Л.Энх-Амгалан сайд аа, танилцуулгаа хий.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгээд яах вэ, хэдэн минут байгаа билээ. Байнгын хороон дарга аа. Тийм үү. Эхлээд мэдээлэл өгч байгаа учраас гайгүй байх. Тийм ээ. Аль болохоор жаахан товчхон яая гэж бодож байна.

Өнөөдрийн хоёр Байнгын хорооны нэгтгэсэн хурлаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаарх өнөөгийн байдлуудыг сонсоод, нөхцөл байдлууд юу байгаа юм, цаашид ер нь ямархуу асуудлуудыг яаж шийдвэрлэх вэ гэдэг талаар шийдлүүд ярилцах ёстой гэж би ойлгож байгаа.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хоёр хамтарсан хуралдаан дээр би 6 чиглэлээр мэдээлэл өгөхөөр бэлдлээ.

Нэгдүгээрт нь, ерөнхий мэдээлэл гэдэг нь үндсэндээ Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо. Ингээд энэ хүүхдүүдээс ер нь нийт хэдэн хувь нь сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролд хамрагдаж байгаа вэ гэсэн энэ нөхцөл байдлуудын нэг статистик тооныхоо мэдээллүүдийг эхлээд өгчихье гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ерөнхийдөө ямархуу хуулиуд ер нь шинэчлэгдэж байгаа юм, ямархуу хууль журмууд шинэчлэгдэж байгаа юм.

Гол нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал дан ганц Боловсролын

яам биш салбар дундын зохицуулалтаар явдаг учраас Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамдын сайд нарын түвшинд ямархуу журмууд, маягтууд шинэчлэгдэж байгаа вэ гэдэг талаар нэг мэдээлэл өгчихье гэж бодож байна.

Гуравдугаарт нь, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ер нь энэ боловсролын үйлчилгээ олгоход суралцах орчин ер нь ямархуу байгаа юм бэ. Яг өнөөдрийн байдал яг юу байгаа юм.

Цаашдаа ер нь яг ямархуу нөхцөл байдлыг сайжруулах ямар арга хэмжээ авах гэж байгаа юм, ямархуу санхүүжилтийн эх үзүүрүүд шаардлагатай юм гэдэг талаар.

Дөрөвдүгээрт нь, багш, хүний нөөцийн чиглэлээр.

Тавд нь, одоогийн байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж байгаа энэ салбар дундын зохицуулалтаар үзүүлж байгаа санхүүжилтийн тогтолцоо ер нь ямархуу тогтолцоогоор явж байгаа юм бэ гэдэг асуудал.

Эцэст нь гурван яамны энэ салбар дундын зохицуулалтаар хийгдэж байгаа ажлууд, тулгамдаж байгаа асуудлууд гэсэн ийм зургаан чиглэлээр Та бүгдэд мэдээлэл өгье гэж энэ мэдээллүүдийг бэлдлээ.

Нэгд нь, өнөөдөр ерөнхийдөө Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэд нарын хэдэн хувь нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа вэ гэдэг талаар цөмөөрөө нэг хэдэн тоо харья гэж бодож байна.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 0-ээс 18 насны хүүхдийн тоо яг өнөөдөр 11 мянга 835 байна. Г.Мөнхцэцэг дарга аа, П.Анужин дарга аа.

Энэ тоо гурван яамны яг нэгтгэсэн тоо. Хуучин бол бас гурван яам өөр өөр тоонууд яриад явдаг байсан.

Ингээд ямар ч байсан өнгөрсөн жилээс сар бүхэн энэ гурван яамны сайд нарын түвшинд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлтэй сар бүхэн уулздаг уулзалтын дүнд статистик тоо нэг болсон байгаа.

Ингээд 11 мянга 385 хүүхэд байна.

Энэ дотроос бид 7 төрлөөр ангилж байгаа юм. Энэ олон улсын ангилал нь бас ийм ангилал байдаг юм билээ. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд нь 2422, сэтгэцийн бэрхшээлтэй гэдэг дотор аутизм, даунтай хүүхдүүдийг оруулаад 2263, хавсарсан бэрхшээлтэй хүүхэд 1152, харааны бэрхшээлтэй хүүхэд 1087, хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд 825, сонсголын бэрхшээлтэй хүүхэд 645, бусад бэрхшээл гэдэгт Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хоёр сайдын хамтарсан юугаар байнгын асаргаанд байх өвчтэй хүүхдүүд гэж ингэж хамрагддаг юм байна. Энд удаан хугацаанд хэвтэрт байгаа хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ордог юм байна. Энэ бол нэг 3342 хүүхэд өнөөдөр байна гэсэн ийм тоо гурван яамны нэгтгэсэн тоог өнөөдөр ингээд танилцуулж байна.

Тэгээд яагаад ингээд хөгжлийн бэрхшээл бүрээр нь танилцуулж байна вэ гэхээр ерөнхийдөө цаашдаа бид яг энэ чиглэл рүү бид яг хүүхдийн өөрийнх нь

хөгжлийн онцлогтой хөгжлийн хэрэгцээнд нь тулгуурласан боловсролын энэ үйлчилгээг зохион байгуулах ийм бодлого, стратеги гарч байгаа учраас энэ тоонуудыг өнөөдөр ингэж онцолж дурдаж байгаа юм.

Ингээд нийт 11 мянга 385 хүүхдүүдээс яг боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа 8228 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна гэдэг ийм тоо өнөөдөр байна.

Сургуулийн өмнөх боловсролын түвшинд 1930 хөгжлийн бэрхшээлтэй гэж бүртгэгдсэн хүүхэд байгаагаас 1498 хүүхэд хамрагдаж байна.

Ерөнхий боловсролын түвшинд 9500 хүүхдийн бүртгэлээс 5653 хүүхэд ерөнхий боловсролын түвшин боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Мэргэжлийн боловсрол дээр 643, дээд боловсрол дээр 414 гэсэн хүүхдүүд энэ түвшин бүр дээр ийм боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.

Гэхдээ энэ дээр бас нэг ийм юм байна. Гишүүд нэлээн анхаарна биз. Юу гэхээр бид боловсролын насаа болохоор 0-ээс 2 нас, 2-оос 5, 6-аас 18 нас гэж ингэж авч явдаг. Энэ бүртгэлүүд угаасаа ингэж хийгддэг.

Гэтэл манай Статистикийн ерөнхий газраас одоо яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, бүртгэлийг хийхдээ 0-ээс 4, 5-аас 9 гэж ингэж ийм маягтаар авдаг учраас манай статистикийн бүртгэлийн маягт, Боловсролын яам, гурван яамны маягтууд хоорондоо ингээд зөрж байгаа учраас одоо яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоог Монгол Улсад яг

нэгдсэн нэг маягтаар авах ийм шаардлага үүсэж байна гэж би харж байгаа юм.

Тэгэхээр ингээд маягтууд нь өөр байдаг учраас ингээд тооны зөрүүнүүд ингээд ийм тооны зөрүүнүүдтэй явдаг юм байна гэдэг ийм зүйлүүд ажиглагдсан.

Тэгээд үүнийг бид нэг болгоё гэж бодож байна.

Цэцэрлэгийн насны 430 хүүхэд, сургуулийн насны 3817 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энэ боловсролын үйлчилгээг авч чадахгүй байна гэдэг ийм дүгнэлт гарсан.

Ингээд 2-оос 18 насны хүүхдийн нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 36 хувь нь энэ боловсролын үйлчилгээний гадна үлдээд байна гэж байгаа юм. Энэ бас их том тоо.

Тэгээд ер нь яагаад ингээд энэ хамрагдахгүй ингээд энэ боловсролын үйлчилгээнээс гадна үлдээд байдаг юм бэ гэдэг энэ шалтгаануудыг тодруулъя гэж бид өнгөрсөн оноос хойш хоёр гурван удаагийн ийм судалгаануудыг хийгдсэн.

Ингээд судалгаанууд дээр гарч байгаа шалтгаанууд дээр энэ байнгын асаргаанд байгаа нь 982, хэвтэрт оноштой байдаг, эцэг эх нь боловсролын үйлчилгээ авах, хүүхдээ хамруулах сонирхолгүй байгаа, хэл ярианы бэрхшээл, зайнаас сурдаг, сургуулийн насанд хүрээгүй, насан туршийн боловсролын төвд хамаарагддаг гэсэн энэ шалтгаануудыг тайлбарласан байгаа.

Ийм шалтгаануудаар одоо ингээд энэ нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 36 хувь нь өнөөдөр энэ боловсролын үйлчилгээнд хамрагдаж

чадахгүй байна гэсэн дүгнэлтүүдийг бид хийсэн юм байгаа юм.

Тэгээд Ерөнхий юу бол одоо бид нарт нэг ийм хоёр асуудал байна.

Нэгдүгээрт нь, яг энэ сургуульд хамрагдаж байгаа гэж бид ингэж зарлаж байгаа 8100 орчим хүүхдэд яг энэ боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа гэж статистик тоо байгаа ч гэсэн яг цэцэрлэг, сургууль дээрээ өнөөдөр хүүхдүүдийн яг энэ хөгжлийн орчин, хөгжлийн хэрэгцээ шаардлага дээр тулгуурласан үйлчилгээг өгөх орчин бүрдсэн үү гэдэг асуудал байгаа юм.

Хоёрдугаарт, хүний нөөцийн асуудлууд нь байна уу.

Гуравдугаарт нь, бид нарын ярьдаг нөгөө хувьсах зардал буюу хувьсах зардлаар энэ санхүүжилтийг олгож чадаж байна уу гэсэн нэг ийм зүйл дээр бид яг үнэхээр тодорхой маш их том эрсдэл үүссэн байна. Нэгдүгээр асуудал бол.

Тийм учраас би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр өнөөдөр ингээд бид энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 64 хувийг сургуульд хамрагдаж байгаа, цэцэрлэгт хамрагдаж байгаа гэж байгаа энэ тоо бодит амьдрал дээр яг үнэхээр ингээд ийм боловсролын үйлчилгээ сэтгэл хангалуун авч байна гэж би хэлж чадахгүй.

Ер нь асуудал яг энэ дээр байгаа юм билээ.

Хоёр дахь асуудал бол энэ хүүхдүүд яагаад, хэрхэн яаж энэ боловсролын үйлчилгээнд яаж хамруулах вэ гэдэг асуудлууд дээр бид нарын өмнө

нэлээн том тулгамдаж байгаа асуудлууд байна.

Энэ дээр мэдээж энэ эрх зүйн орчны шинэчлэлүүд хийгдэх. Нийтээрээ ер нь нийгмээрээ энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тухай ойлголтуудыг нийгмийн хүрээнд нэг ойлголтуудаа зөв болгодог нийгмийн хүрээнд энэ нэг mindset-ээ өөрчлөх зайлшгүй шаардлагууд байна гэж ингэж харж байгаа юм.

Ингээд хамрагдахгүй байгаагийн шалтгаануудыг аваад үзэхээр ерөнхийдөө яах вэ, бид өнгөрсөн жилээс ажиллаж байна даа. Зургаа дахь удаагийн уулзалт хийж байна.

Тэгээд яагаад ийм олон удаагийн уулзалтууд хийгээд байгаа юм гэхээр Монгол Улсад өнөөдрийн байгаа одоо яг ингээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эхийн хэвлийнээс төрөөд тэгээд ерөнхий боловсролын сургууль төгсөх, мэргэжлийн сургууль төгстлөө ер нь ямар ийм юугаар явдаг юм бэ, ямар замын зураглал байгаа юм бэ гээд нэг ийм замын зураглал өнөөдөр Монгол Улсад байгаа юм.

Ингээд энэ замын зураглалуудыг харахаар үндсэндээ бүх хүүхдүүдийг хамруулчих ийм замын зураглалуудыг хийсэн байна. Хийсэн байна. Бас тогтолцоо байна.

Гэтэл энэ замын зураг бүр дээр ингээд нөгөө ягаан дэвтрээс авхуулаад хүүхэд эхээс мэндлээд, тэгээд ягаан дэвтрээрээ нөгөө эх нь хяналтад яваад тэгээд өрхийн эмнэлгээрээ дамжаад ингээд явдаг энэ тогтолцооноос нь бид хөөж харахгүй бол энэ дээр ерөөсөө яг

ингээд ийм алхам бүр дээр, шатлал бүр дээр ерөөсөө яг бид нарын төрийн үйлчилгээ үзүүлж байгаа энэ үйлчилгээнүүд ерөөсөө яг ингээд ийм яг шаардлага хангахгүй хэмжээнд хүрчихсэн байж байгаа.

Бүтцийн хувьд, тогтолцооны хувьд, эрх зүйн хувьд, хүний нөөцийн хувьд, санхүүжилтийн хувьд. Тэгээд салбар дундын зохицуулалтууд ингээд байхгүй. Тус тусдаа үйлчилгээнүүд. Эрүүл мэндийн яам нь тусдаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь тусдаа. Боловсролын яам нь тусдаа байгаа учраас ерөөсөө энэ байгууллага дээр суурилсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдэд өгдөг үйлчилгээний тогтолцоог л бид хийсэн юм байна. Байгууллага дээр суурилсан.

Энэ бол өнгөрсөн 20 жилд бид нарын хийсэн сул тал. Өнөөдөр маш их мөнгө зардаг. Төрөөс. Маш их олон олон улсын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн. Маш их олон судалгаанууд хийгдсэн. Маш их олон бодлогын зөвлөмжүүд өгсөн мөртлөө өнөөдөр тэр 11 мянга 180 хүүхэд чинь өнөөдөр яагаад тэр хүүхдүүдийн ар гэр, эцэг эхчүүд, асран хамгаалагч нар өнөөдөр сэтгэл дундуур байгаа юм бэ гэхээр ерөөсөө л өнөөдөр яг энэ газрын зураглалын энэ тогтолцоогоо зурсан зураглалын тогтолцоо хүнээ бодож хийсэн тогтолцоо биш байгууллагыг тойрч зурсан ийм газрын зураглалын тогтолцоо юм байна. Үүнийгээ одоо ингээд бид эхний ээлжид ингээд даруйхан шинэчлэх ийм шаардлага үүсэж байгаа гэж бид харж бодлогуудаа төлөвлөж байна.

Хоёрдугаар асуудал сурах орчны хувьд. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүүхдүүдийг авч байгаа, 9 тусгай

сургууль, цэцэрлэг, 1095 ердийн сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсролын төв болон явуулын багш нараар бид боловсролын үйлчилгээг хүргэж байгаа.

Ингээд үзэхээр бараг үндсэндээ нийт сургууль, цэцэрлэгийн 65 хувьд нь бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг авч боловсролд хамруулж байна гэдэг ийм статистик байгаа юм.

Гэтэл харамсалтай нь өнөөдөр энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг авч байгаа цэцэрлэг, сургуулиуд яг тэр орчныг бүрдүүлж чадсан уу гэвэл энэ орчин бүрдэж чадаагүй байгаа.

Өнөөдрийн байдлаар гэхэд нийт 101 сургууль л үндсэндээ гарц, орцоо янзалсан байна. 101 сургууль. 700 сургуулиас 6 сургууль үндсэндээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд орох гарц орц. Ороод нөгөө сургуулийн орчинд шаардагдах тэр ариун цэврийн байгууламж гэх мэтчилнээр энэ зүйлүүд үнэхээр хангагдаж үнэхээр чадаагүй байна. Үүнийг бид хүлээн зөвшөөрөх ёстой.

Тэгэхээр энэ хүрээнд бид ерөнхийдөө хийхийн тулд ямархуу санхүүжилтүүд шаардлага байна. Нэг сургууль дээр нэг 230 сая төгрөг гээд ингээд нийт 480 сургуулиар үржүүлэхэд ямар ч байсан 11 тэрбум төгрөг байх юм бол бид одоо нөгөө нийт сургууль, цэцэрлэгийнхээ 65 хувьд нь хөгжлийн бэрхшээлт тэгээд хүүхдүүд авч сургаж байгаа цэцэрлэг, сургуулиудынхаа энэ орчныг сайжруулахад нэг ийм боломжууд байгаа юм байна гэж харж байгаа.

Тэгэхээр үндсэндээ нийт сургуулийн чинь нөгөө 68 хувь нь ийм тохируулгат орчин бүрдээгүй ийм ердийн сургуулиуд байна.

Тийм учраас бид үнэхээр тэр хүүхдүүд дээр орчин бүрдчихсэн гэж хэлэхэд их тийм гэнэн дүгнэлт болох болов уу гэж бодож байна.

Явуулын багшийн үйлчилгээнд 307 суралцагч хамрагдаж байгаа. Сургуулийн өмнөх боловсролд 75, ерөнхий боловсрол дээр 232, насан туршийн боловсролын багш нар явуулын үйлчилгээг үзүүлж байгаа.

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа суралцагчдад сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй ашиглуулдаг.

Сонсголын бэрхшээлтэй суралцагчийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн баталж дохионы хэлний хичээлийн цагийг нэмэгдүүлсэн ийм том дэвшил гарсан байгаа гэдгийг би хэлье гэж бодож байна.

Энэ дээр бас дахиад ганцхан энэ сургуулийн орц гарц, ариун цэврийн байгууламжаас гадна яг нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг авч сургахад шаардагддаг энэ “Хүүхэд хөгжлийн төв” гэдэг асуудал хөндөгдөж бас тавьж байгаа юм.

Үндсэндээ өнөөдөр “Хүүхэд хөгжлийн төв” 105 танхим байна гэсэн ийм тоо байна. 21 аймаг дээр.

Ингээд цаашдаа бид ер нь бүх сургуулиуд дээрээ бүх хүүхдүүдээ ер нь

ердийн сургуулиудаар авна гэх юм бол нэг сургууль дээр ингээд энэ “Хүүхдийн хөгжлийн төв”-ийг барихад 100 орчим сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай. 600 сургууль дээр бид үүнийг хийнэ гэх юм бол 60 орчим төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Тэгээд нийтдээ бид 70 тэрбум төгрөг байх юм бол үндсэндээ хүүхдийн орчин бүрдүүлэх “Хүүхэд хөгжлийн төв”. Ингээд сургууль, цэцэрлэгүүдийнхээ орц гарц, ариун цэврийн байгууламжуудыг бүрэн шийдвэрлэх ийм боломжууд байгаа.

Тэгээд яагаад би энэ тоог өнөөдөр базаж хэлж байна вэ гэхээр манай эмэгтэй гишүүд маань Эрдэнэтийн санхүүжилтээр ариун цэврийн байгууламж, хөдөөгийн нүхэн жорлонг халах энэ санаачилгыг гаргаж 100 тэрбумын санхүүжилтийг тавьсан учраас яг үүнтэй адилхнаар ер нь бид энэ 2024 оны улсын төсөв дээр 70 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тавих юм бол одоо Монгол Улс яг жинхэнэ утгаараа цэцэрлэг, сургуулиуд хүүхдийн хөгжлийн танхимын хувьд ч гэсэн, гарц орцын хувьд ч гэсэн, ариун цэврийн байгууламжийн хувьд ч гэсэн ингээд хүүхдээ яг боловсролын үйлчилгээ үзүүлэх ийм орчин нөхцөл дэд бүтцүүдийг бүрдүүлэх бас ийм боломж байгаа юм шүү гэдгийг би онцлоод хэлчихье гэж бодож байна.

Сурах орчны тухайд нэг ийм нөхцөл байдалтай байна.

Гуравдугаарт нь, ер нь өнөөдрийн энэ санхүүжилтийн тогтолцоо, төсвийн хувьд бас хэдэн тоо танилцуулья гэж бодож байна.

Өнөөдөр 2023 оны улсын батлагдсан төсвөөр бид нийт сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол дээр 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилтүүд хийгдэж явж байгаа.

Нэг хүүхдэд олгож байгаа нөгөө хувьсах зардал 3 дахин үржүүлж өгч байгаа юм. Бид нар одоо. Нэг хүүхдийн дундаж юу 910 мянган төгрөг байгаа шүү дээ. Тэрийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа цэцэрлэг, сургууль дээр энэ хувьсах зардлыг бид гурав дахин үржүүлж өгдөг. Гэтэл харамсалтай нь энэ 2 сая 700 мянган төгрөг гэдэг бол одоо яг бүтэн жилийн турш, 10 сарын турш олгож байгаа ийм мөнгө.

Гэтэл харамсалтай нь яг өнөөдөр бодит өртөг 6-аас 10 сая төгрөгийн ийм бодит өртөг гарч байна гэдэг ийм юм гарч байна.

Тэгэхээр бид энэ хувьсах зардлуудаа нэлээн өөрчилж эргэж харах ийм шаардлага үүсчихсэн байна гэж харж байна.

Орчны хувьд, хичээлийн хэрэглэгдэхүүний хувьд, багшийн цалингийн хувьд. Ингээд ганцаарчилсан сургалтын хөтөлбөрүүдийн хувьд гээд ингээд ийм хувьсах зардлуудынхаа бид аргачлалуудыг нэг өөрчлөх ийм хэрэгцээ шаардлага үүсэж байна гэж харж байгаа юм.

Энэ дээр сайн жишгүүд байна. Өнөөдөр Монгол Улсад энэ “Хүүхдийн хөгжлийн төв” гэж хэлбэр бүрээр байгуулагдаж байгаа яг бид нарын нөгөө цаашдаа энэ тусгай сургууль, цэцэрлэгүүдийг бид ер нь энэ хэв

шинжүүдийг нь жаахан өөрчилье. Энэ бол ийм дэмжих төв байх ёстой юм байна.

Тэгэхгүй бол бид нарын өнөөдрийг хүртэл явж байгаа зөвхөн боловсролын үйлчилгээ гэдэг талаас нь хардаг. Гэтэл тэр хүүхдүүд чинь ганцхан боловсролын үйлчилгээ гэхээсээ илүү нөгөө хөдөлгөөн засал, хэл засал. Тийм ээ. Хөдөлмөр засал. Тийм ээ. Одоо ингээд тодорхой нөгөө нийгмийн халамжийн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээнүүд нь яг тэндээ асаргаа, сувилгаанууд нь сургууль, цэцэрлэгүүд дээрээ олгогддог ийм дэмжих цөвийн бусад улсуудад байдаг энэ жишиг рүү ойртуулах ийм хэрэгцээ шаардлага байна гэж харж байгаа. Ингэж чадах юм бол бид нөгөө сургуулийн гадуур байгаад байгаа 40 орчим хувь дээр байж байгаа нөгөө хүүхдүүдээ хамруулах ийм боломж бүрдчих болов уу гэж бодож байна.

Тэгэхээр 7 ийм хөгжлийн төв өнөөдөр Монгол Улсад ажиллаж байна. “Энэрэлийн түүчээ”, “Бяцхан сувд”, “Хүслийн ордон” гээд. Энэ дээр 105 хүүхэд нөгөө дэмжих төв маягаар үйлчилгээнүүдээ. Боловсролынхоо үйлчилгээг ч авч байна, эрүүл мэндийнхээ үйлчилгээг ч авч байна, тодорхой нийгмийн халамжийн үйлчилгээнүүдийг ч авч байна.

Ингээд нэг хүүхдээс цагийн хөлс нь 40 мянган төгрөг авдаг юм байна. Энэ 7 төв. Тэгээд нэг сар явуулахад 200 мянга орчим төгрөг эцэг, эхээс гардаг. Ингээд ерөнхийдөө жилийн төлбөрүүд нь нэг саяаас 500-аас хоёр сая төгрөгийн төлбөртэй ийм хувийн сайн гэж хэлэхээр, жишиг болохуйц ийм хөгжлийн төвүүд өнөөдөр ийм чадавхууд, үндэсний чадавхууд бас бүрдсэн байна.

Яагаад би энэ тоог хэлээд байна вэ гэхээр ер нь цаашдаа бид ерөнхийдөө одоо яг энэ хүүхдүүдэд боловсролын цогц үйлчилгээг үзүүлэхийн тулд ерөнхийдөө бид яг өнөөдөр Монгол Улсад бий болчихсон байж байгаа энэ хүүхдийн загвар маягаар ажиллаж байгаа энэ хүүхдийн хөгжлийн төвүүдээр. Энд байгаа боловсон хүчнүүдээр дамжиж энэ үйлчилгээг хийх юм бол бас тодорхой үндэсний хэмжээнд чадавх хүрчихсэн байна гэдгийг би онцолж хэлье гэж бодож байна.

Ингээд төсөв, санхүүгийн хувьд нэг ийм мэдээлэл өгчихье.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамран сургах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэл рүү нэлээн хэдэн ажлуудыг бас хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар Боловсролын ерөнхий хуульд бид энэ тэгш хамруулах чиглэлээр бид тусдаа тэгш хамран сургалт, ялгаатай хэрэгцээ гэх мэтчилнээр урьд өмнө нь байгаагүй нэг ийм бүлэг оруулж өгч байгаа.

Ингэх юм бол энэ манай боловсролын ерөнхий хууль дээр энэ хууль маань батлагдаж гарах юм бол яг жинхэнэ утгаар нь бид энэ хүүхдэд боловсролын үйлчилгээ авч чадахгүй байгаа, өөрийнхөө хөгжлийн бэрхшээлийн онцлогоос шалтгаалаад одоо энэ давхардсан хөгжлийн бэрхшээлтэй, өнөөдөр гэрээрээ байгаа, удаан хугацаанд энэ өвчин зовлонтой байгаа хүүхдүүдэд энэ боловсролынх нь үйлчилгээг ингээд ийм онцлогтойгоор нь, тухайн хөгжлийн бэрхшээлийнх нь онцлогтойгоор нь энэ үйлчилгээг хүргэх энэ эрх зүйн орчин ингэж нээгдэх юм гэдгийг би онцолж хэлье.

Тийм учраас энэ Боловсролын ерөнхий хуулиа уг нь нэг өдөр ч гэсэн алгасахгүй хэлэлцүүлмээр л байгаа юм. Тийм ээ. Ийм хамгийн чухал асуудал өнөөдөр үүгээр ингээд хөндөгдөж байгаа байхгүй юу.

Тэгээд мэдээж Монгол Улсын Засгийн газраас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хуулийг удахгүй өргөн барих гэж байна. Эрүүл мэндийн багц хуулиуд бас өргөн баригдана.

Ингээд Боловсролын ерөнхий хууль, Эрүүл мэндийн ерөнхий хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай энэ гурван хуулийг хооронд нь салбар дундын уялдаатайгаар энэ эрх зүйн шинэчлэлтүүдийг хийж чадах юм бол бид нэлээн том дэвшил гарах ийм боломжууд нь байгаа болов уу гэж харж байна.

Ингээд 2021 оноос хойш ямар ч байсан Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарч энэ уулзалт хийдэг болсноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт шинэчлэн батлах тухай гээд гурван сайдын хамтарсан тушаалууд гарсан. Энэ тушаал 6 сар тутамд шинэчлэгдэж байгаа.

Тэгээд энэ хүрээнд ингээд яг салбар дундын зохицуулалтуудыг хийх ийм тодорхой шинэ эрх зүйн ийм орчнууд үүссэн гэдгийг би хэлье гэж бодож байна.

Энэ хүрээнд манай Боловсролын яамнаас шаардлагатай байгаа ганцаарчилсан сургалтын хөтөлбөрүүд,

ингээд энэ дохионы хэлний журмууд, хос хэлний хуулийн боловсруулалтууд, хөдөлмөр засал, хөдөлгөөн засалчаар давхар мэргэжил эзэмшиж байгаа иргэдэд энэ боловсролын зээлийн сангаас буцалтгүй тусламж олгох энэ боломжуудыг бүрдүүлсэн.

Танхимын сургалтад тогтмол хамрагдаж боловсролын үйлчилгээ авч чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээ үзүүлэх энэ хөгжлийн төвүүдийг турших ажлуудыг бид эхэлж байна. Сая миний нөгөө дурдсан 7 төвтэй хамтарч.

Ингээд цаашдаа бид энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх энэ зураглалын меню үзүүлсэн. Энэ тогтолцооны зураглалуудаа шинэчлэх, санхүүжилтүүдийг шийдвэрлэх, санхүүжилтийнхээ тогтолцоог шийдвэрлэх, хувьсах зардлынхаа аргачлалуудыг өөрчлөх энэ ажлууд эрх зүйн шинэчлэлийн хувьд хийгдэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ. Энэ асуудал бол боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр халамж, хамгааллын түвшинд ерөнхийдөө ингэж бид ер нь харъя гэж бодож байгаа.

Ингээд эхнээс нь авхуулаад бид мэргэжлийн байгууллагуудын оролцоотой ер нь эрт илрүүлгийн тогтолцоог бид хийх шаардлагатай юм байна. Салбар дундын мэдээллийн нэгдсэн санг үүсгэх ийм шаардлага үүсэж байгаа.

Тэр хүрээнд манай яам нэг захиалга өгөөд. Миний дараа хоёр презентац хийгдэнэ **е-хүртээмж** гээд яг

бүх төрлийн хөгжлийн бэрхшээлээсээ шалтгаалаад ерөөсөө төрөөс үзүүлж байгаа бүх үйлчилгээнүүдийг нэг платформаар авах энэ аппликэйшн хийгдээд дуусаж байна.

Тэгээд үүний өнөөдөр энэ пресентацууд хийгдэнэ.

Хоёрт нь, дохионы хэлний prohand гэсэн энэ аппликэйшн бас манай яамны захиалгаар хийгдээд дуусаж байгаа.

Энэ аппликэйшн нь одоо энэ боловсролын салбарт нэвтрэх юм бол дохионы хэлний хэлмэрчгүйгээр бүх хүүхдүүд энэ хичээл сургуулиуддаасаа хоцрохгүй байх агуулгуудаа авчих энэ шинэ боломжуудыг бүрдүүлж өгнө. Энэ пресентацуудыг хийнэ.

Ингээд цогц үйлчилгээг хүргэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн арга замыг бид баталгаажуулах эрх зүйн орчныг сайжруулах ийм шаардлага байна.

Цогц үйлчилгээний санхүүжилтийн салбар дундын механизмыг бий болгох, өртөгт суурилсан зардлыг нэвтрүүлэх ийм шаардлага үүсэж байна. Тэгш хамран сургах боловсролын талаар нийгэмд чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулах соёлыг бий болгох, хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах.

Энэ хүрээнд сая Монгол Улсын Засгийн газраас батлагдсан Монгол Улсад тэргүүлэх болон хэрэгцээтэй мэргэжлүүдийн жагсаалтад бид энэ хөдөлгөөн засалч, хэл засалч, хөдөлмөр засалч гэсэн яг шаардлагатай байгаа энэ мэргэжлүүдийг бид энэ дээр оруулж өгсөн байгаа.

Тэгээд энэ мэргэжлээр сурах гэж байгаа хүүхдүүд дээр энэ боловсролын зээлийн сангаас тэтгэлэг олгох энэ зохицуулалтууд хийгдсэн.

Өнгөрсөн жилээс бид ерөнхийдөө энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нар дээр тулгуурлаж 70 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарыг бид яг энэ чиглэлээр бэлдэж байна. Энэ чиглэлээр. Ингэх нь илүү их тийм богино хугацаанд их үр дүнтэй байх юм болов уу гэж бодож байгаа. Энэ хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр.

Боловсролын байгууллагын суралцагчийг дараагийн шатад дэвшин суралцах, хөдөлмөрийн зах зээлд гаргах, амьдралд бэлтгэх, чиг баримжаа олгох үйлчилгээг нэвтрүүлэх гээд.

Энэ бол яг үндсэндээ манай энэ боловсролын салбарын үнэхээр сул тал.

Тэгэхээр үндсэндээ нөгөө сургуулийн өмнөх боловсролоос ерөнхий боловсролын сургууль рүү шилжих, ерөнхий боловсролын сургуулиас мэргэжлийн боловсрол, дээд боловсрол руу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд шилжих асуудлууд маш тодорхойгүй байсан юм билээ. Маш тодорхойгүй байсан.

Тэгэхээр үүнийг ерөнхийдөө ингээд яг түвшин түвшингөөс нь ингээд шилжүүлдэг ийм уян хатан тогтолцоог бид нэвтрүүлэе гэдэг нэг ийм эрх зүйн шинэчлэлүүдийг хийж байна.

Ингээд бүх шатын боловсролын байгууллагад мэдээж энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгож байгаа

боловсролтой холбоотой бүх үйлчилгээнүүдийг тарифжуулах. Үүнийг санхүүжилтийн төрөөс даадаг тогтолцоог нэвтрүүлэх ийм шаардлага байна гэж үзэж байгаа.

Ингээд үндсэндээ миний ярих гэж байгаа зүйл бол ийм зүйлүүдийг би ингээд базаад ярьчихъя гэж бодож байна. Ойрын хугацаанд хийж байгаа ажлууд бол өнгөрсөн 10 жилийн хугацаанд ерөнхийдөө яг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар Монгол Улсын Засгийн газар олон улсын төсөл хөтөлбөрүүдээс авсан төслийн жагсаалтуудаа бид гаргаж байна. Эрүүл мэндийн яамны чиглэлээр, Хөдөлмөр, нийгэм хамгааллын чиглэлээр, Боловсролын яамны чиглэлээр маш их олон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжсэн юм байна лээ.

Харамсалтай нь хоорондын ийм уялдаа байхгүй учраас энэ их үр дүн, эргээд ярихад их хүндрэлтэй ийм асуудал байгаа юм. Манай Боловсролын яам дотроо ч гэсэн Дэлхийн банкнаас ч энэ чиглэлээр зээл, тусламжууд авдаг. ЖАЙКА-гаас ч авдаг. Тийм ээ. Азийн хөгжлийн банкнаас ч авдаг. КОЙКА-гаас ч авдаг.

Тэгээд хоорондоо яг ингээд нэг ийм уялдсан нэг цонхоор бодлогоо харж байсан, төлөвлөж байсан, хэрэгжүүлж байсан. Энэ тал дээр бид их сул тал байгаа учраас энэ чиглэл рүү одоо энэ алдаа дутагдлуудаа засаж ажиллая гэсэн нэг ийм бодлогууд бас хийгдэж байгаа.

Өнгөрсөн хугацаанд бас энэ олон улсын байгууллагуудаар хийгдсэн судалгаа маш их олон судалгаанууд хийгдсэн юм байна.

Маш олон бодлогын зөвлөмжүүд өгөгдсөн юм байна.

Харамсалтай нь өнөөдөр ингээд энэ хийсэн судалгааны үр дүн, энэ олон улсын байгууллагуудаас өгсөн бодлогын зөвлөмжүүдийг бид үндсэндээ ингээд ажил хэрэг болгож чадаагүй учраас өнөөдөр бид нарын боловсролын түвшинд байгаа 10 хүүхдийнхээ 6-г боловсролд хамруулаад 4-ийг нь хамруулаагүй. 4-ийг нь хамруулахдаа яг тэд нарт яг ямар хэрэгцээ шаардлага дээр үндсэн ийм боловсролын үйлчилгээ байх юм бэ гэдгээ тодорхойлж чадаагүй ийм л нөхцөл байдал бид нарын өмнө үүссэн байна.

Үүнийг шийдэх энэ хэлбэр нь саяын миний мэдээлэл өгсөн 6 хэлбэрээр энэ ажлуудаа зохион байгуулах юм бол бид ямар ч байсан дунд болон урт хугацаанд тодорхой үр дүн гарах болов уу гэсэн ийм хүлээлттэй, ийм төсөөлөлтэй байгаа.

Тэгээд өнгөрсөн оноос хойш сар бүхэн гурван салбарын сайдын хүрээнд сайдын түвшинд Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын сайдын түвшинд сар бүхэн бид яг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрийн бус байгууллагуудтай уулзалт хийж тогтмолжсон. Сар бүхэн хийж байгаа.

Тийм учраас энэ их тийм үр дүнгээ өгч байгаа. Яагаад гэвэл сарын дараа уулзахад заавал ч үгүй нэг ажил бүтээж байж очих ёстой учраас гурван яамны хамтын ажиллагаа ч гэсэн нэлээн уялдаж ингэж ажиллах ийм тогтолцоо бий болсон байгаа.

Тэгээд ерөнхийдөө хэлэхэд өнөөдрийн хэлэлцүүлгээс гарч байгаа энэ саналууд. Мэдээж эндээс би бодлогын зөвлөмжүүд, энэ чиглэлүүд гарах болов уу гэж бодож байна.

Тэгээд 5 сардаа багтаагаад гурван эрх зүйн баримтуудаа Улсын Их Хурал дээр өргөн баригдсаны дараа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өгдөг эрүүл мэндийн, нийгмийн хамгааллын, боловсролын энэ үндэсний газрын зураглалынхаа тогтолцоог дахиад шинээр алдаа мэдгийг нь гаргаад зураад авъя.

Үүнийгээ дагасан бүтэц зохион байгуулалтууд, санхүүжилтийнхээ тогтолцоог хийх юм бол бид тодорхой үр дүнд хүрэх ийм боломж байна гэдгийг Та бүхэнд хэлье.

Ингээд Та бүхэнд анхаарал тавьсанд маш их баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хамтарсан Байнгын хороодын хуралдаан болж байна.

Хуралдаанд Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан танилцуулга хийлээ.

Ингээд ажлын хэсэгт ирсэн байгаа. Ажлын хэсэгт ирсэн албан тушаалтнуудыг танилцуулъя.

Л.Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, С.Зулпхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, С.Энхболд эрүүл мэндийн дэд сайд, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Л.Цэдэвсүрэн Боловсрол, шинжлэх

ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Т.Ням-Очир Боловсролын Ерөнхий Газрын дарга, Б.Гантулга Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга, А.Саруул Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын тэгш хамран сургалтын бодлогын удирдлага, зохицуулалтын хариуцсан ахлах мэргэжилтэн, П.Оюунаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга байна, О.Хуягцогт Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Г.Оргилболд Hand Pro компанийн захирал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас С.Тунгалагтамир Хөдөлмөр, нийгмийн хамгааллын. Байхгүй юу. Б.Ундрал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Б.Ундрал дарга байна уу? Байна. М.Цогтбаатар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга, Н.Өлзийхутаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Бадрахбаяр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ц.Нямсүрэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, С.Энхбат Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Мандхай Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга байна. Ч.Отгонцэцэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн,

Ч.Ариунболор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн, Эрүүл мэндийн яамнаас М.Оюунчимэг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ө.Энхмаа Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын эмнэлгийн тусламжийн үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч.

Төрийн бус байгууллагын төлөөллүүд бас ирсэн байна. Б.Диваа Энэрэлийн түүчээ төрийн бус байгууллагын менежер, Ц.Дарьсүрэн Энэрэлийн түүчээ төрийн бус байгууллагын зохицуулагч, Г.Үнэнбаяр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үнэн шударга холбоо төрийн буй байгууллагын тэргүүн, Д.Нямжав Хүүхэд, гэр бүлийн тэгш хөгжил төрийн буй байгууллагын тэргүүн.

Ингээд асуудал маань өөрөө бас их том асуудал учраас ингээд гурван яам, төрийн бус байгууллагуудтайгаа хамтарсан ийм өргөн бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Ингээд сайдын мэдээлэлтэй нэмж Боловсрол, шинжлэх ухааны яамнаас дахиад мэдээлэл өгөх юм байна.

Ингээд хоёр дахь мэдээллийг сонсчихъё. Хоёр дахь мэдээллийг хэн өгөх юм? Дугаартай микрофон дээр очиж суугаарай. 4 номер уу? 4 номерын микрофон дээр сууя.

Хоёр дахь мэдээллийг Г.Оргилболд дарга өгнө.

Г.Оргилболд: Сайн байцгаана уу. Энд хүрэлцэн ирсэн бүх хүнд энэ өдрийн

амар амгаланг айлтгая. Намайг Hand Pro компанийн гүйцэтгэх захирал Г.Оргилболд гэдэг.

Өнөөдөр би Та бүхэнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн цогц платформыг танилцуулахаар хүрэлцэн ирлээ.

Монгол Улсад одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд 106 мянга гаруй хүн байгаа. Эдгээр иргэдийн хувьд тулгамдаж байгаа нэлээдгүй олон асуудал байдаг.

Яг үүнээс 5 асуудлыг аваад үзэхээр нэгдэх хүртээмжгүй байдал. Хүртээмжгүй байдлыг нь хоёр хувааж үзье.

Нэг нь, мэдээ мэдээллийн хүртээмжгүй байдал. Жишээ нь, та бүхэн ингээд ямар нэгэн байдлаар мэдээллийн сувгуудаар мэдээлэл явдаг. Энэ нь өөрөө цаанаа сонсголын бэрхшээлтэй иргэдэд, харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байдаг.

Юу вэ гэхээр текстэн мэдээлэл явахаар харааны бэрхшээлтэй иргэд маань хүлээж авахад хүндрэл үүсдэг. Видео дүрсэн мэдээлэл явахаар дохионы хэлмэрч байхгүй бол тэр мэдээлэл маань сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байдаг гэсэн үг.

Хоёрт, дэд бүтцийн асуудал. Энэ нь юу вэ гэхээр хөдөлгөөний буюу тэргэнцэртэй иргэд маань гадуур явахад хүндрэл их үүсдэг. Яг хаана нь ямар хүртээмжтэй байгаа, ямар үйлчилгээний төв байгууллагууд маань тэргэнцэртэй хүнд хүртээмжтэй, нольтой, орц гарцтай байна вэ гэдэг талаар мэдээлэл байдаггүй.

Хоёрдугаар асуудал бол эрүүл мэндийн үйлчилгээ. Энэ маань яг нэгдсэн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдгээрийн асран хамгаалагч, эцэг, эхчүүдэд яг ямар үйлчилгээ ямар зарчмаар яаж хүрч байгаа талаар ер нь ерөнхий дэлгэрэнгүй мэдээллүүд хомс байгаад байгаа юм.

Дээрээс нь, үйлчилгээнүүд маань илүү уламжлалт хэв маяг буюу биеэр очиж авах шаардлагатай байгаад байгаа гэсэн үг.

Гуравт, боловсролын үйлчилгээ. Одоо нөгөө тэгш хамруулан сургах гээд боловсролын үйлчилгээ нь бусад нөгөө цэцэрлэгт орох, мөн ерөнхий боловсролын сургуульд ороход яг аль сургуулиуд нь хүртээмжтэй байгаад байгаа юм. Одоо байгаа нөгөө 9 тусгай сургууль, цэцэрлэгээс гадна өөр сургуулиуд маань тухайн хүүхдүүдэд хүртээмжтэй байна уу, үгүй байна уу гэдэг мэдээлэл. Мөн цэцэрлэгт хамрагдахаар бол тэр хамрагдах тухайн цэцэрлэгт хүсэлт гаргах гэдэг зүйлсийг маань одоо уламжлалт байдлаар авч байгаа.

Үүнийг яг энэ дээр оруулж өгөх ёстой юм байна гэж үзэж байгаа.

Дөрөвт, зөвлөн туслах үйлчилгээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань 21 аймаг, 330 сумд тархан суурьшсан байгаа.

Эдгээр иргэдийн хувьд зайлшгүй сэтгэл зүйн эрүүл мэндийн зөвлөн туслах үйлчилгээ болон эрүүл мэндийн үйлчилгээ, бусад үйлчилгээнүүдийг алсын зайнаас авах боломж хомс байгаад байна.

Заавал ямар нэгэн харьяа дүүрэг, агентлаг дээрээ очиж авах шаардлага үүсээд байдаг.

Тавд, бид бүхэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэж яриад байдаг. Гэтэл нэг зүйлийг орхигдуулаад байгаа юм. Энэ нь юу вэ гэхээрээ эцэг эх асран хамгаалагчдыг оролцуулах, тэдгээрийг дэмжих, тэдгээр хүмүүсийн сэтгэл зүйн эрүүл мэнд дээр анхаарах. Мөн тэдгээр хүмүүсээр дамжуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч үйлчлэх гэдэг зүйл дээр дутмаг байгаад байгаа юм.

Үүнийг бид бүхэн олж хараад дараах **е-хүртгэмж** гээд платформыг танилцуулж байгаа.

Энэхүү платформ хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон эцэг, эх, асран хамгаалагчдад зориулсан платформ байна.

Энэ дээр нийт 11 модулийг оруулж өгч байгаа юм. Энэ нь нэгд хөгжлийн бэрхшээлтэй иргэний профайл буюу хөгжлийн бэрхшээлтэй гэж тогтоогдсоноос хойш тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэн маань эрүүл мэндийн үйлчилгээг яг ямар шатаар яаж авах, боловсролын үйлчилгээг яаж авах. Мөн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг яаж авах гэх мэт бүх алхмуудыг загварчилсан байна гэсэн үг.

Хоёрт, боловсролын үйлчилгээ тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асран хамгаалагчид маань тухайн хүүхдээ боловсрол эзэмшүүлэхэд яг хаана яаж, ямар дарааллаар, яаж үйлчилгээ авах уу гэдэг бүх цогц үйлчилгээ маань энд багтана гэсэн үг.

Гуравт, эрүүл мэндийн үйлчилгээ цаг захиалах болон бусад эрүүл мэндийн зөвлөн туслах үйлчилгээ гэх мэт зүйлс маань энд орж ирнэ гэсэн үг.

Дөрөвт, нийгмийн халамжийн үйлчилгээ.

Энэ дээр халамжийн тэтгэмж гэж байдаг. Бусад халамжтай холбоотой нэг удаагийн тусгай хэрэглэгдэхүүний нөгөө хүсэлт гаргах гэх мэт үйлчилгээнүүдэд хамрагдана гэсэн үг.

Тавд, цахим төрийн үйлчилгээ гэж байгаа.

Энэ дээр бид бүхэн одоо цахим үндэстэн больё гээд e-mongolia болон e-business, e-халамж гэх мэт платформуудыг хөгжүүлээд явж байгаа.

Энэ платформуудыг заавал бүгдийг нь инстолдахгүйгээр тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн **е-хүртгэмж** платформ дотор нь оруулаад өгчих боломж байна гэж харж байгаа юм.

Зургаад нь, алсын зайн зөвлөн туслах үйлчилгээ гэж байгаа юм.

Энэ нь юу вэ гэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн маань орон нутагт байна уу, хаа байх газраас үл хамаараад цахимаар бүхий л үйлчилгээг хүртгэмжтэй байдлаар видео дүрс болон чатан байдлаар авах боломж байна гэсэн үг.

Долоод, шилэн төсөл.

Яг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн маш олон төрийн бус байгууллагууд төрөөс санхүүжиж үйл

ажиллагаа явуулдаг. Гэхдээ энэ нь өөрөө ил тод нээлттэй бус байгаад байгаа юм.

Юу вэ гэхээр ямар нэгэн байдлаар санхүүжилт авчхаад, тэр санхүүжилт нь яг ямар төсөлд, яг яаж эхлээд, яаж дуусаж байгаа юм юу юу хийгдэх, ямар төрлийн бэрхшээлтэй иргэд маань хамрагдах гэдэг мэдээлэл нь байдаггүй.

Төгсгөлд нь тайлан нь хүртэл тэнд уг нь орох ёстой. Тэгэхдээ тэр мэдээлэл одоогоор байхгүй байгаа.

Тэгэхээр бид бүхэн үүнийг илүү ил тод, нээлттэй болгоод, яг төрөөс ямар нэгэн байдлаар санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж байгаа бол тэр бүх төслүүдийг нээлттэй байлгая гэж байгаа юм.

Ингэснээр нөгөө төсвийн шилэн дансны тухай, бусад энэ нөгөө яг хаана ямар зардал тавигдаад тэр нь яаж хэрэгжиж байгаа гэдэг ил тод байдал нээгдэнэ гэсэн үг.

Наймд, цахим судалгаа.

Энэ нь юу вэ гэхээр одоогоор яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ амьдралын чанар, бусад нийгэм хүртээмжтэй байх талаар судалгаануудыг явуулахдаа 35-аас 45 хоногийг зарцуулж байгаа юм. 30-аас 45 хоногийг. Яг ингэхдээ нөгөө тухайн төслийн баг гараад ч юм уу, эсвэл энэ судалгаа хийдэг мэргэжлийн байгууллагуудаар явдаг.

Энэ дээр нөгөө маш их хэмжээний зардал мөнгө, цаг хугацаа үрэгдээд байна. Тэгвэл энэ e-хүртээмж платформ байх юм бол тэр дээр тухайн судалгаа авах иргэд маань байна. Энэ дээр шууд 2-оос 3 хоногийн дотор цахим судалгааг форум

бөглөөд судалгаа явуулаад үр дүнгээ авчих боломжтой. Ингэснээр цаг хугацаа болон зардлыг 95 хувь хүртэлх бууруулах боломж байна гэж харж байна.

Есөд, хүртээмжгүй байдлыг мэдээлэх.

Яг хөдөлгөөний бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй иргэд маань гадуур явахдаа хаана ямар байгууллага хүртээмжтэй байгаа, ямар байгууллага хүртээмжгүй байгаа талаар мэдлэг ойлголт байхгүйгээс үүдэлтэйгээр маш их цаг хугацааг алддаг.

Дээрээс нь, очоод хүртээмжгүй байхад тэндээ маш их стрессдэх. Тэгвэл үүнийг газрын зураг дээр хүртээмжтэй, хүртээмжгүйгээр нь ил тод байлгачихъя. Тухайн иргэн нь ямар нэгэн газар очлоо. Хүртээмжгүй байх юм бол тэрийгээ шууд мэдээлчихдэг. Тэр мэдээлсэн нь өөрөө тухайн байгууллагад танайх ингээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байна. Үүнийгээ ингээд шийдэж өгнө үү гэдэг хүсэлт байдлаар оршдог. Тэр нь буцаагаад шийдэгдэх юм бол хариу хүртээмжгүй байдлыг мэдээлсэн иргэнд таны мэдээлсэн хүртээмжгүй байдал маань шийдэгдлээ гэдэг энэ мэдэгдэл ирдэг байхаар.

Аравт, санал хүсэлт, гомдол.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд яг ямар үйлчилгээ авах, ямар асуудал байгаад байгаа талаараа нээлттэй иймэрхүү хурал чуулган дээрээс хэлэхээс биш бусдаар ингээд хэлж чаддаггүй. Зөвхөн төлөөллийн хэдэн хүн яваад байдаг. Тэгвэл үүнийг ил тод болгочихё.

Хүн болгон хүссэн үедээ ороод өөрийнхөө санал гомдол, шийдүүлэхийг

хүсэж байгаа асуудлаа тавьчихдаг. Тэр дээр нь бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань санал өгөөд хамгийн их дэмжигдэж байгаа саналууд нь тухайн шийдэгдэх асуудлын жагсаалтад ороод явдаг байя гэж байгаа юм.

Арван нэгд, хүртээмжтэй мэдээ мэдээллийг түгээх.

Энэ нь юу вэ гэхээр одоо бид бүхний яг ярьж байгаа энэхүү асуудлууд маань текстэн байдлаар сошиал платформд орлоо гэхэд тэнд маань хүртээмжгүй байгаад байгаа. Сонголын бэрхшээлтэй иргэд, бусад харааны бэрхшээлтэй иргэд хүртээмж.

Тэгвэл энэ мэдээллүүдийг хүртээмжтэй байдлаар e-хүртээмж платформ дээр яаралтай мэдээллүүдийг шууд оруулчихдаггүй. Яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд холбогдолтой. Одоо жишээ нь онцгой байдал маргааш цаг агаарын онц байдал үүсэх гэж байна шүү гэх юм бол тэрийг бүх хүнд хүртээмжтэй байдлаар яг энэ e-хүртээмжтэй платформд оруулчих юм нэгдсэн хүртээмжтэй мэдээлэл түгснээр ямар нэгэн аюул гамшгаас сэргийлж чадна гэж үзэж байгаа. Бусад нийгмийн оролцоог.

Тэгэхээр бид бүхэн цахим үндэстнийг цогцлоохоор явж байгаа. Яг үүнтэй уялдуулаад e-mongolia платформ маань маш төрийн үйлчилгээг цахимжуулж байгаа.

Тэгэхээр e-mongolia платформыг бид бүхэн усан завь гэж үзэх юм бол доор дэд системүүд маань сэлүүрэн болж байгаа гэсэн үг. Яг үүнтэй адилхан e-хүртээмж платформыг бид бүхэнд гаргаж ирснээр яг энэ хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн бүхий л төрлийн үйлчилгээг нэгдсэн нэг цэгээс авдаг болно гэсэн үг.

Энэ дээр давуу тал юу үүсэж байна гэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд тухайн өөртэй нь холбогдолтой бүхий л үйлчилгээг нэг доор авч чадаж байна. Мөн хүртээмжтэй байдлыг хангасан. Харааны бэрхшээлтэй иргэн ч бай, сонголын бэрхшээлтэй иргэн ч бай, ямар ч хүн байсан тэндээс хүртээмжтэй байдлаар мэдээлэл авдаг болно гэсэн үг.

Гуравт, бид бүхэн e-mongolia системтэй уялдаатай ажиллана. Гэхдээ e-mongolia систем дотор ажиллахгүй учраас илүү тухайн e-mongolia системийн давуу систем байдлаар явна гэсэн үг.

Дөрөвт, төрийн цахим системүүд интеграци хийх боломжтой.

Одоо төрийн байгууллагууд, төрийн яамдын цахим системүүд дээр интеграци хийгдсэнээр тухайн яамдын цахим системд орж байгаа мэдээллүүдийг e-хүртээмж рүү татаад шууд хүртээмжтэй болгоод тухайн иргэдэд хүргэх боломжийг нээж байгаа юм.

Ингээд үр дүнд нь бид бүхэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрт шаардлагатай бүхий л үйлчилгээг ямар нэгэн чирэгдэлгүйгээр хурдан шуурхай авах боломжийг бүрдүүлж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн үйлчилгээнүүдийн тоон статистик мэдээллийг нэг цэгт төвлөрүүлнэ гэсэн үг.

Өмнө нь Л.Энх-Амгалан сайдын хэлсэнчлэн салбар салбар болгон нь өөр өөр статистик тоон мэдээлэл гаргадаг

биш, яг нэг цэг дээр нэг статистик тоон мэдээллийг оруулж ирнэ гэсэн үг.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеэр очиж авах шаардлагатай үйлчилгээг цахимжуулснаар төр зардлаа хэмнэх, төрийн бүтээмжийг дээшлүүлнэ гэж харж байгаа юм.

Мөн хүртээмжтэй цахим жишиг дэд бүтцийг бий болгож байгаа гэсэн үг. Одоо байгаа нөгөө цахим системүүд маань харааны бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдаг. Сонголын бэрхшээлтэй хүмүүст төдийлөн хүртээмжгүй байдаг.

Тэгвэл бид бүх хүнд хүртээмжтэй нэг ийм платформыг гаргаад өгчих юм бол дараа нь энэ жишгээрээ бусад платформуудыг шийдэл болгоод явчих боломж байна гэж харж байгаа юм.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бодит хэрэгцээ, санаа хүсэлт дээр тулгуурлан оновчтой бодлого, шийдвэр гарах боломж бүрдэнэ. Нөгөө нэг санал хүсэлт гомдол дээр сууриалаад бид бүхэн бодит тухайн иргэнийхээ үзэл бодол дээр тулгуурласан шийдлүүд гарах боломжтой гэсэн үг.

Хамгийн сүүлд нь салбар дундын мэдээллийн нэгдсэн сан үүснэ. Яг гурван яамдууд маань хамтарч яг энэ систем дээр оролцсоноор илүү яг уялдаатай мэдээллийн сан нь нэгдсэн нэг байдлаар гарах цогц тогтолцоо бий болно гэж харж байгаа юм.

Ингээд анхаарал хандуулсан явдалд баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Г.Оргилболд захиралд баярлалаа.

Сайдын мэдээлэл болоод Г.Оргилболд захирлын мэдээлэлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд нэрсээ өгье.

П.Анужин гишүүнээр тасалъя.
Б.Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Өнөөдөр Боловсролын сайд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд рүү чиглэсэн ямар ажил хийж байгаа, ямар бодлого баримталж байгаа юм бэ гэдэг талаарх мэдээллийг бидэнд өглөө.

Ерөнхийдөө мэдээлэлтэй байгаа. Яалт ч үгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд рүү чиглэсэн энэ асуудал гурван яамны дунд орхигдоод түрүүн бас хоёр сайд нь хоорондоо ярилцаж байлаа. Арав гаруй жил орхигдсон энэ ажил. Бид чиглэлээ олгох ёстой гэдэг дээр үнэхээр санал нэгдэж байгаа.

Төрийн болон төрийн бус байгууллагууд энэ чиглэлээр хамтран санал бодлоо солилцсон хэвээрээ байгаа.

Л.Энх-Амгалан сайдын саяын тайлбарласан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх тогтолцооны зураглалыг маш ихээр хүлээж байгаа. Өөрөөр хэлэх юм энэ зураглал гарснаараа гурван яамдын хамтын ажиллагаа нэг доор нэгтгэгдэж хүүхэд суралцах, эрүүл мэндээр хамгаалуулах, халамжийн үйлчилгээ авах энэ бүх боломж нэг доор төвлөрнө гэсэн ийм ойлголттой байгаа.

Тэгээд зураглалыг боловсруулж байна л гэдэг ийм явц явагдаад байна. Тийм ээ. Жил гаруй хугацаа өнгөрлөө гэж би тооцоолж байна. Одоо бид 2024

оныхоо төсвийг ярилцах цаг хугацаа ер нь дөхөж байна.

Төсвийн хуулийн шинэчлэл явагдаж байна энэ цаг хугацаанд бид жоохон ажлыг түргэвчлэхгүй бол ерөнхийдөө хоцроод зураглал батлагдсаны дараа баахан төсөв гараад ирдэг. Төсөвгүйгээр бид нарын ажил явахгүйгээр ийм асуудал болох вий гэдэг нэг зүйл.

Нөгөөтээгүүр энэ дээр ялгаатай хэрэгцээт хүүхдийг дэмжих төвийг байгуулах асуудлыг боловсруулж байна гэсэн байна. Тус төв нь мөн Боловсрол, шинжлэ ухааны яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүжилт, зохион байгуулалт, үйлчилгээний цогц төв байх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон асран хамгаалагчид зориулсан нэгдмэл үйлчилгээ үзүүлнэ.

Үйлчилгээний талаар сонсох юм сайхан. Гэхдээ өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй “Хүүхдийн хөгжлийн төв” маань үйл ажиллагаагаа жигдрүүлж чадаагүй хэвээрээ байгаа.

Хоёр дахь шатлалын үйлчилгээ үзүүлж байгаа тусгай эмнэлэг гэж байгаа боловчиг төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статустайгаар эрүүл мэндийн даатгалаар санхүүжсэн байдалтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа.

Тэгэхээр энэ төвөө, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвөө таны тийм ээ, төлөвлөж байгаа Ялгаатай хэрэгцээт хүүхдийг дэмжих төв болгох боломж байдаггүй юм уу гэдэг нэг ийм асуулт.

Нөгөөтээгүүр ялгаатай хэрэгцээт хүүхэд гэдэг энэ нэр томъёолол өөрөө олон улсын нэр томъёоны ангилалдаа орсон нэр томъёолол уу, үгүй юү? Бид өнөөдөр хуулиараа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй гэдэг ийм нэр томъёоллоор явж байгаа.

Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөө ажиллаж байгаа бүхий л төрийн болон төрийн бус байгууллагуудтай ярилцахад хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нэр томъёоллоороо байгаа.

Нөгөөтээгүүр хувьсах зардлаа бид та нэмье гэдэг энэ саналыг биш гурав дахин нэмж өгч байгаа гэж байна. Тийм ээ.

Өнөөдөр төсвийн задаргааг харахад хүүхэд бүрд хувьсах зардал зарцуулж байгаа. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдээ гурав дахин хувьсах зардал олгож байгаа гэж байгаа боловчиг нөгөөдөх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулж ажиллаж байгаа төрийн бус байгууллагууд. Түрүүний таны хэлсэн долоон ч байгууллага байгаа гэсэн. Тийм ээ.

Эдгээр байгууллагууддаа санхүүжилтийг нь нэмж өгөх. Та түрүүн хэлсэн. Өөрөөр хэлбэл сардаа 200 мянган төгрөгийн төлбөр аваад хүүхдүүдээ эмчилж байгаа, сургаж байгаа гэсэн. Тэгвэл яг хувьсах зардлаа эдгээр төвүүддээ мөн адилхан олгоод хүүхдүүдээ эмчлүүлэх, асруулах тэр боломжийг нэмээд төрийн бус байгууллагуудаа дэмжих боломж ер нь хэр байна вэ гэдэг талаар нэг зүйлийг тодруулъя.

Нөгөөтээгүүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын салбар бүрийн гурван хүний төлөөллийг орон тооны болгоё гэсэн ийм санал байна. Энэ дэмжих сайшаалтай. Тийм ээ. Ийм санал байна гэж би харж байна.

Ер нь цогц дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилтийг шийдвэрлэх зайлшгүй шаардлага байгаа гэдэг дээр Та бүхэн санал нэгдэх байх.

Ер нь санхүүжилтээгүйгээс шалтгаалаад энэ төвүүд маань үйл ажиллагаа явуулах боломжгүй болоод байгаа. Яг үнэхээр боловсролын сайдын хувьд үнэхээр талархалтай байгаа. Өөрөөр хэлэх юм бол хөдөлгөөн засал, хөдөлмөр заслаар суралцаж байгаа.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Дараа нь асуултаа авчих. Б.Жаргалмаа гишүүний асуултад Л.Энх-Амгалан сайд хариулъя. Ялангуяа тэр зураглалтай холбоотой төсөв мөнгөний талаар нэлээн тодорхой хариулт өгөх байх. Нэр томъёоны талаар тодорхой хариултуудыг өгөөрэй.

Л.Энх-Амгалан: Б.Жаргалмаа гишүүн ээ, энэ зураглал яагаад удаад байна вэ гэж байна. Энэ удна. Энэ их амархан гарахгүй.

Тэгээд гол нь яах вэ зураг зурах амархан л даа. Тэгээд яг бодитойгоор. Хэрэв бид үнэхээр өмнө нь гарсан зураглал амьдрал дээр хэрэгжчихсэн бид арай өөр түвшинд юм яриад суух байсан байх.

Тэгэхээр ингээд зураг зурдаг, үйлчилгээ, бүтцүүдийг хийдэг,

санхүүжилтийн тогтолцоог хийдэг. Тэгээд үүнийхээ араас хэрэгжилт дээр мониторинг хийдэг нэг ийм бүтэн циклээр нь л бид ер нь авч явахгүй бол энэ бол хэчнээн ч сайхан зураг зураад энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйлчилгээнд том ахиц дэвшил гарчихгүй болов уу гэж бодож байна.

Тэгээд би түрүүн хэлсэн. Яагаад удаад байгаа юм бэ гэж. Энэ удаагүй. Үүнийг чинь 01 сарын 01-нээс л сар бүрийн уулзалтаар ингээд л хэлэлцүүлээд л яваад байгаа юм. Манай төрийн бус байгууллагынхан ч гэсэн, манай иргэд ч гэсэн наадах чинь хэзээ гарах юм бэ гээд. Мэдээж өдөр бүхэн хүлээж байгаа. Нэг өдрийн өмнө ч гэсэн эрт гараасай л гэж бодож байгаа.

Тэгэхээр үүний чинь цаана нь нөгөө эрх зүйн шинэчлэлээ бид хийж авах ёстой байгаа юм. Эрүүл мэндийн ерөнхий хуулиа бид хурдан өргөн баримаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрхийнхээ тухай хуулийг бид хурдан өргөн баримаар байна. Ингээд Боловсролынхоо ерөнхий хуулийг хамгийн гол нь хурдан баталж өгмөөр байна. Хоёр дарга аа.

Боловсролын ерөнхий хууль дээр чинь тэгш хамран сургах ингээд цоо шинэ ийм тогтолцооны асуудал эрх зүйн шинэчлэлт хийж байгаа учраас ядахдаа боловсролынх нь тэр үйлчилгээний эрх зүйн шинэчлэлүүдийг батлаад хуулиараа баталгаажуулаад өгчих юм юм бол нэгэнт хууль батлагдахаар үүний дагуу нөгөө санхүүжилтийн тогтолцооны асуудлууд. Би энэ 2024 оны төсвийг л би алдаж болохгүй гэж бодоод байгаа байхгүй юу. Яг Б.Жаргалмаа гишүүнтэй би санал нэг байна.

Тийм учраас ингээд энэ Боловсролын ерөнхий хууль, Эрүүл мэндийн хууль, энэ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хамгаалах тухай хуулиудаа яг ингээд зэрэг хэлэлцээд, тэгээд тэрнийхээ дагуу. Одоо бид нар дээр ерөнхийдөө Б.Жаргалмаа гишүүн бид энэ тооцоо хийгдээд байгаа юм. Сая би нөгөө зөвхөн нэг хүүхдийг хувьсах зардлыг яг тэр хөгжлийн бэрхшээлийнх нь онцлогтой уялдуулж зөвхөн нэгхэн жишээ дурдлаа шүү дээ. Тийм ээ.

Тийм учраас бараг үндсэндээ энэ чинь долоо, найман нийтлэг ийм хөгжлийн онцлог байгаа учраас тэр бүр дээр тодорхой өртгүүд, хөтөлбөрийн өртгүүд их өөр өөр гарах ёстой юм байна. Ганцаарчилсан сургалтуудын өртгүүд их өөр гарах ёстой юм байна гэж байгаа юм.

Тэгээд ерөнхийдөө бид одоо байгаа энэ тусгай цэцэрлэг, сургуулиудынхаа статусыг ч гэсэн харж үзэхгүй бол энэ их тийм хоцрогдсон ийм байгаа байхгүй юу. Ерөөсөө яг манайх шиг ингээд нэг ийм нэг хэсэг хүүхдүүдээ аваачаад нэг цэцэрлэгт, нэг сургуульд ингээд хашчихсан ийм улс орон их цөөхөн байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр цаашдаа бид үнэхээр тийм хүнд хэлбэрийн гэдэг юм уу, хавсарсан ийм хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд дээр боловсролын үйлчилгээ үзүүлэхэд хүнд нь хүнд. Гэхдээ үүнийг дэмжих төв хийх юм бол болох юм билээ. Тэр дээр нь яг тэр асаргаа, сувилгааных нь үйлчилгээ, тэр хэл засал чинь байдаг, хөдөлгөөн засал чинь байдаг, сэтгэл зүй чинь байдаг. Тийм ээ. Ингээд тэр бүх тогтолцоонуудыг нь бид ерөнхийдөө одоо байгаа тусгай цэцэрлэг, сургуулиа

дэмжих төв болгож өөрчилье. Үүнийг чинь дахиад бид хууль дээрээ нэр томьёог нь шинэчилж оруулж байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ чиглэл рүү нэлээн ийм эрх зүйн асуудлууд, тогтолцооны асуудлууд, санхүүжилтийн асуудлууд байгаа учраас энэ жаахан удах ийм хэмжээнд байгаа. Бид гэхдээ энэ 6 сар гэхэд ерөнхийдөө энэ зураглалуудаа эцэслээд гаргачихъя гээд энэ бүх оролцогч байгууллагуудтайгаа ингэж тохирч байгаа.

Хоёр дахь асуудал бодоо тэр нөгөө явж байгаа энэ дэмжих төвүүдийг санхүүжүүлэх энэ тогтолцоо нь бас байхгүй.

Тэгэхээр бид шууд төсвөөс энэ мөнгийг чинь санхүүжүүлээд явна гэдэг ийм нөгөө эрх зүйн тогтолцоо байхгүй учраас чадахгүй байгаа юм. Гэхдээ бид нэгэнт юу хэлж зовлон тоочиж суугаад яах вэ. Ямар ч байсан ингээд нэг тогтолцоо бий болгохын тулд нэг туршилт хийе гээд бид энэ Жи Пи И /**Global Partnership for Education (GPE)**/ гээд олон улсын энэ боловсролын төлөө байгууллагаас манайд 5 сая доллар өгсөн юм байгаа юм. Үүний 2 сая орчим долларыг ерөнхийдөө яг энэ дэмжих төвүүдийн жишиг төвүүдийг нэг ийм төв байх юм гэдгийг энэ долоо дээрээ нэг тулгуурлаад энэ жил одоо ингээд нэг хийгээд үзчихье. Энэ хичээлийн жил дуустал хоёр сар, гуран сар дутуу байна. Энд нэг туршаад үзчихье.

Тэгээд намраас ингээд энэ.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Б.Жаргалмаа гишүүн тодруулах уу? Б.Жаргалмаа гишүүний нэмэлт асуулт. Микрофон өгье.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Тэгэхээрээ үнэхээр яалт ч үгүй бид боловсролын хуулиа яаравчлах, Эрүүл мэндийн яамнаас орж ирэх, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас орж ирэх Халамжийн тухай хууль. Энэ хуулиудыг түргэтгэх шаардлагатай байгаа. 2024 ондоо бид багтааж энэ ажлуудыг эхлүүлэх шаардлага зүй ёсоор урган гарсан гэдгийг Та бүхэн анзаарч харж байгаа байх гэж бодож байна.

Энэ дээр нэг зүйлийг тодруулаад хэлэхэд бид Монгол Улс хүн амынхаа тооллогыг бүрэн гүйцэд хийдэг үү, үгүй юү гэдэг дээр дахиад л асуудал үүсэж байгаа байхгүй юу.

Зүгээр Боловсролын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хорооны тоонууд зөрдөг. Өөрөөр хэлбэл маягтуудыг нь өөр байдлаас шалтгаалаад хүүхдийн бүртгэлийн тоо зөрдөг.

Тэгэхээр бид хүмүүстээ нөгөө зорилт бүлгийн хүмүүстээ хүрч чадахгүй байна гэдэг бол энэ гурван яамдын хэлхээ холбоо, дундах харилцаа холбоо алдаатай байгаагаас шалтгаалаад бид иргэдийг хохироож байна л гэдэг зүйл.

Тэгэхээр энэ мэт ажлуудыг бид түргэтгэх зайлшгүй шаардлага байгаа шүү гэдгийг дахиад хэлье.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөгөө төрийн бус байгууллагуудын ажил.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Б.Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Баярлалаа. Бас нэг үеэ бодвол урагшилж байгаа ажлууд, үр дүн ингээд сонсогдож байгаад баярлалаа.

Гэхдээ хэд хэдэн асуулт байна. Одоо энэ хотод байгаа долоон төв дээр туршилт явуулья гээд тэгж байна. Гэтэл хөдөө орон нутагт энэ асуудал маш хүнд байгаа.

Хөдөө орон нутагт байгаа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд дээр бид ямар арга хэмжээ авах вэ? Жишээлбэл, манай Завхан аймагт нийтдээ яг ерөнхий боловсролын сургуулийн насны 261 хүүхэд. Үүнээс 73 нь бүр хүнд хэлбэрийн бэрхшээлтэй. Сургуулийн өмнөх боловсролд 25 хүүхэд. Тэгээд цэцэрлэг байхгүй. Ийм байдалтай.

Тэгш хамруулан сургах гээд нөгөө зорилгынхоо дагуу сургууль, цэцэрлэгт оруулахаар багш нарт нь заах арга байхгүй. Эцэг, эхчүүдэд ойлголт байхгүй учраас ялгаварлан гадуурхалт шууд явагддаг ийм асуудал байгаад байна.

Тэгэхээр энэ Боловсролын хуульд энэ home school буюу гэрээр хичээл заах энэ бас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд, ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ээж, ааваар нь дамжуулан, эсвэл гэрээр нь очиж заах ийм заавал зохицуулалт шаардлагатай юм шиг харагдаж байна.

Тэгээд хөдөө орон нутагт энэ зохицуулалт ямар байх вэ? Эрүүл мэндийн яам энэ эцэг, эхчүүдийг соён гэгээрүүлэх ажлыг ер нь хийж байна уу? Энэ тархины саажилт гэдэг өвчин өвчин

биш оюуны өндөр чадвартай ийм хүмүүс байдаг.

Тэгээд энэ хүүхдүүдийг эцэг, эхчүүд нь мэддэггүйгээс дааж чадах үедээ хүүхдээ тэвэрч явж байгаад дааж чадахгүй болохоороо ингээд орхиод явдаг. Өнөөдрийн энэ 11 мянга 600 гэж байгаа энэ нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо яг бодит тоо мөн үү?

Тэгэхээр энэ залуу эцэг, эхчүүдийг ялангуяа тархины саажилттай хүүхэдтэй болчихсон эцэг, эхчүүдийг багаас нь энэ хүүхдийг хөдөлгөөнийг нь засаж чадах юм бол оюуны өндөр потенциалтай хүүхдүүд байдаг юм гэдгийг ерөөсөө эцэг, эхчүүд нь өөрсдөө мэддэггүй.

Энэ дээр Эрүүл мэндийн яам юу хийж байдаг юм бол. Үүнийг асууя.

Мөн ялгаварлан гадуурхалт гэж нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргэнцэртэй явах замаас илүү хэцүү нэг ийм асуудал байна. Энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэдэг энэ нэр томъёогоо хүртэл сая бид Боловсролын багц хуулийг хэлэлцэж байхдаа ер нь энэ нэр томъёог сольё гээд тэгсэн.

Тэгээд энд байгаа гурван яамныхан маань энэ асуудал дээр анхаарч өгөөч. Энэ парламентын хугацаанд энэ том том хуулиуд орж ирэх гэж байгаа. Хэлэлцэгдэх гэж байгаа энэ үед хөгжлийн бэрхшээл гэдэг энэ нэрнээс салмаар байна.

Хөгжлийн онцлог гэдэг юм уу, тусгай хэрэгцээтээр явах ёстой юу. Энэ дээр нэг тийм нэрнээсээ авхуулаад ялгаварлагдахгүй байхаар ийм нэр томъёотой болмоор байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ “Ээлтэй ертөнц” гээд нэг төрийн бус байгууллага байгаа. Энэ идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд бүгдээрээ л бие биеийгээ мэдэж байгаа.

Энэ байгууллагад “Эм Си Эс” компанийн залуучууд хүмүүнлэгийн тусламж үзүүлж бараг сая долоон жил энэ байгууллагыг, төрийн бус байгууллагыг ажиллах боломжоор хангалаа.

Энэ хүмүүс яаж байна гэхлээр яг энэ Л.Энх-Амгалан сайдын хэлээд байгаа шиг нэг өрөөндөө чихмэл тоглоом үйлдвэрлээд нөгөө өрөөндөө хүүхдээ ингэж харж нэг ээж, аав нь ингэж хоол ундыг нь хийгээд хөдөлгөөн заслыг нь хийж өгч байгаа.

Гэтэл энэ яамнаас дэмжинэ л гэдэг, дэмжинэ л гэдэг ямар төрийн бус байгууллагуудаа дэмжээд байдаг юм. Одоо энэ төрийн бус байгууллага үүд хаалгаа хаахад хүрч байна.

Энэ чихмэл тоглоомоор энэ төрийн бус байгууллага яаж байгаа вэ гэхээр хүүхдүүдийнхээ эмийн мөнгийг л олдог ийм л үйл ажиллагаа явуулдаг байгаа юм.

Эцэст нь нэг зүйлийг асуумаар байна. Энэ дохионы хэлийг биднийг бага байхад ингээд сонирхоод хүүхэд болгон үүнийг сайн дураараа сурчихдаг байсан. Одоо сонсголын бэрхшээлтэй хүмүүсийг үйлчилгээ үзүүлэх, нийгэмд харилцахад энэ дохионы хэлийг нийтийн хэрэглээ болгож үүнийг заавал албадлагаар бус сонирхлынх нь дагуу энэ дохионы хэлийг сургах ажилд холбогдох яамд юу хийж

байгаа вэ? Энэ асуултуудад эхлээд нэг хариулт аваадахъя. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Б.Баярсайхан гишүүний асуултад Л.Энх-Амгалан сайд. Тэр томьёоны асуудлаар хоёр гишүүн хоёулаа асуугаад байна. Тэр дээр хариулт өгөөрэй. Л.Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Б.Баярсайхан гишүүн манай яамны Төрийн нарийн бичгийн дарга байсан учраас яг энэ чиглэл рүүгээ бусад гишүүдийн хувьд нэлээн илүү өргөн ойлголттой байгаа гэж бодож байгаа.

Тэгээд гол нь юуны энэ хөдөөд асуудал байна байна. Б.Баярсайхан гишүүн ээ, Яг бид нарын асуудал хүрч чадахгүй байгаа асуудал нөгөө хөдөөд байгаа яг энэ миний нөгөө түрүүний хэлдэг нөгөөх 4200 хүүхдүүдийн чинь ихэнх нь хөдөө орон нутагт байна.

Тэгээд яг Завхан дээр гэхэд ерөнхий боловсролын сургуулийн түвшинд 261, сургуулийн өмнөх боловсролын түвшинд 25 гээд та түрүүн юу хэлэх шиг боллоо. Энэ бол яг одоогийн байдлаар үнэхээр яг тийм ялгаварлан гадуурхалтын түвшинд хүүхдүүдийн эрх зөрчигдөж байгаа асуудал нийтлэг хөдөө орон нутагт байна.

Тийм учраас хууль батлагдахаас өмнө хууль эрх зүйн орчин арай жаахан сайжраххаас өмнө ерөнхийдөө энэ дэмжих төв гэдгийг нөгөө хүнд хэлбэрийн одоо яг ингээд цэцэрлэг, сургууль дээрээ хүрч ирж чадахгүй байгаа гэрээрээ байгаа энэ хүүхдүүд дээр ер нь үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ байвал ер нь ямар хэлбэрээр байж болох юм бэ гэдэг дээр энэ долоон төв дээр нэлээн сайн жишиг байгаа

учраас үүнийгээ ер нь нэг ингээд нэг ажиллуулаад үзвэл.

Одоо энэ дээр чинь 100 гаруй хүүхдүүд байгаа байхгүй юу. Нэгдүгээрт, эрт эрт илрүүлэг. Хоёрдугаарт, тэгээд эртнээс нь тэр дэмжих үйлчилгээнүүдийг нь өгөх юм бол сэргэхгүй хүүхэд гэж байхгүй юм байна лээ шүү дээ. Ер нь бол. Бүх хүүхдүүд л тодорхой хэмжээнд сэргэдэг юм байна лээ. Бүх юунууд нь.

Энэ чиглэл рүү бид ингээд нэг туршилтаа хийчихье. Тэгээд эрх зүйн орчныг нь ингээд нэг энэ хуулиуд дээр байгаа учраас нэг ялгаатай хэрэгцээ гээд бид хууль дээр гаргачихсан. Тэгш хамран сургуулах зарчмаа хууль дээрээ хийгээд өгчихсөн учраас хууль батлагдаад гарахаар одоо ингээд эрх зүйн орчин, энэ санхүүжилтийн тогтолцоонууд нь ингээд бий болохоор энэ дээр тодорхой энэ үйлчилгээг заавал ч үгүй төр өөрөө хийгээд байх шаардлагагүй гэж би үзээд байгаа байхгүй юу. Мэргэжлийн төрийн бус байгууллагууд аутсорсинг хэлбэрээр энэ үйлчилгээг хийчих.

Тэгэхдээ үүний хэмжээнд хотод бол манай энэ зарим төрийн бус байгууллагууд энэ дауны төрийн бус байгууллага, аутизмын эцэг, эхчүүдтэй эцэг, эхчүүдийн төрийн бус байгууллагууд асар өндөр хэмжээнд энэ чадавх бий болсон юм байна лээ. Үндэсний чадавх бий болсон юм байна лээ.

Тэгэхээр бусад энэ хөгжлийн бэрхшээл энэ ялгаатай хэрэгцээнүүд дээр байгаа төрийн бус байгууллагуудаа нэгдүгээрт чадавхжуулъя.

Хоёрдугаарт, хүний нөөцийн хувьд бид ингээд энэ Боловсролын

зээлийн сан. Бид одоо ингээд энэ их дээд сургуулиуд дээр багш бэлдэж байгаа их дээд сургуулиуд дээр хөтөлбөр дээр нь ерөнхийдөө энэ ялгаатай хэрэгцээний асуудлууд, тэгш хамран сургахын энэ концепцуудыг оруулж өгч. Ер нь багш болж байгаа хүн бүхэн нэгдүгээрт ойлголттой.

Хоёрдугаарт, тодорхой ийм арга зүйтэй болж төгсөх энэ боломжоор нь бид хангаж ажиллах нь зүйтэй юм байна гэж бодож байгаа юм.

Дохионы хэлний тухайд уг нь энэ дээр танилцуулъя гэж бид бэлдчихсэн байсан юм. Энэ Hand Pro гээд энэ аппликэйшн бараг ингээд хөгжүүлэлтийнхээ 70, 80 хувьтай явж байгаа. Энэ 09 сарын 01-нээс гэхэд бид ер нь үүнийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын түвшинд ер нь нэвтрүүлчхээд ийм энэ аппликэйшн бараг бэлэн болчихоод байгаа юм.

Тэгээд үүнийг харин зүгээр үүний дараа хэрэв Байнгын хороон дарга боломж гаргах юм бол яг нэг энэ аппликэйшныг бид хоёр минут үзүүлчихвэл Б.Баярсайхан гишүүний асуултад хариулт болчих болов уу гэж бодож байна.

Бусад Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай холбоотой асуудал дээр Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан хариулах уу. Тийм ээ.

Г.Мөнхцэцэг: Эрүүл мэндийн яамтай холбоотой асуулт дээр 2 номерын микрофон дээр нэрээ хэлээд, танилцуулга, хариултаа өгөөрэй.

М.Оюунчимэг: Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Оюунчимэг байна.

Б.Баярсайхан гишүүний хэлж байгаа үнэн. Яг энэ эцэг, эхчүүдийг соён гэгээрүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэдэг зөвхөн эрүүл мэндийн байгууллагаар хүч хүрэхгүй юм байна.

Энэ бол өөрөө тэр тусмаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн байнгын сэргээн засах, хөдөлгөөн засалт, тэр байнгын асаргаа сувилгаа хэрэгтэй юм байна гэдэг дээрээ эрүүл мэндийн салбарын хувьд хоёр яамтайгаа хамтраад энэ цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоон дээр бидний ямар үүрэгтэй байна, яах ёстой вэ гэдгээ улс үндсээр нь зураглалаа гаргаж байна.

Хамгийн эхлээд бид нарын эрүүл мэндийн байгууллага анхан шатаасаа эхлээд хөгжлийн хоцрогдлыг нь маш эрт илрүүлж гэдгээрээ бид 9, 18, 36 сар гэдэг шинэ хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх тогтолцоог бий болгоод, эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр буюу бид нарын хэлдгээр ягаан дэвтэртэй энэ тогтолцоог оруулж ир ирлээ.

Түүндээ эцэг, эхчүүд жирэмсэн цагаас эхлээд та төрсний дараа энэ ягаан дэвтэр гэдгийг ингэж бөглөх юм. Хүүхэдтэй болсон цагаас нь эхлээд энэ хөгжлийн хоцрогдлыг эмч 10, 15-хан минутад үнэлэхээсээ илүү та амьдралынхаа туршид илрүүлж эрт гаргаж ирэх юм гэдэг тогтолцоог бид эх, хүүхдийн ягаан дэвтэр дээрээ суулгаж гаргаж ирж байна. Энэ маань жирэмсэн эхчүүд.

Тэгэхээр бид ард иргэд рүүгээ илүү анхан шатынхаа тусламжид анхаарах. Тэгээд дараагаар нь бид хэд аймаг, дүүргийнхээ нэгдсэн эмнэлэг рүү хөгжлийн хоцрогдлыг нь оношлох цаашдаа төрөлжсөн мэргэжлийн шаардлагатай тусламжийг нь хурдан хугацаа алдалгүй хүргэхэд бид нарын зураглал байгаа.

Тэндээс оношилгоо дүгнэлт гарах юм бол бид хэд салбар комиссоороо нөгөө хөгжлийн цогц хөтөлбөрийнхөө түвшинд гаргаж ирэх юм гэдгийг бид хэд зураглалаа гаргаж явна.

Гэхдээ эрүүл мэндийн байгууллага. Одоо бид төрийн бус байгууллага одоо байгаа хөрсөн дээр байгаа энэ төрийн бусуудыг хийгээд хөдөлмөр, эрүүл мэнд боловсролынхоо асуудлыг шийдэх гээд хүүхдүүдийнхээ асуудлыг шийдэх гээд явж байгаа дээр нь бид хууль эрх зүйн орчин дээр яаж тусгаж өгөх вэ. Энэ нь өөрөө эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авдаг тогтолцоо байдаг бол эрүүл мэндийн байгууллага бус ийм хөгжлийн энэ тэгш хамруулахын тулд үүсгэж байгаа байгууллага дээрээ бид санхүүжилтийн ямар тохиргоог хийх вэ гэдэг дээрээ хууль эрх зүйн орчин дээрээ ярилцаж байна. Тэгэхдээ яах вэ орон нутгийн түвшинд бид нарт хүндрэлтэй асуудал бий. Нөгөө сэргээн засахын эмч, хөдөлгөөн засалчийн эмч нар бол хүндрэлтэй асуудлууд байгаа.

Г.Мөнхцэцэг: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль шинэчилсэн найруулгаараа Нийгмийн хамгааллын яаман дээр явж байгаа байх. Тийм ээ. Энэ хууль өөрчлөгдөж байж энэ шинэчилсэн найруулгаар орж ирж байж

энэ нэр томъёоны асуудлууд цэгцрэх байх.

Тэгэхээр одоо энэ хууль ямаршуу байдалтай байгаа юм. Нэр томъёон дээр Нийгмийн хамгааллын яам дэд сайд хариулт өгчихвөл. Хоёр гишүүн асуулт асуугаад байсан. Тийм ээ. Энэ чиглэлээр хариулт өгчихье.

С.Зулхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ удаагийн амар амгаланг айлтган мэндчилье. Б.Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

Манай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эцэг, эхчүүдийн үүсгэл санаачилгаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг. Маш сайн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.

Эдгээр байгууллагуудын нэг нь “Ээлтэй ертөнц” төрийн бус байгууллага юм. “Ээлтэй ертөнц” төрийн бус байгууллагад 2018 оноос хойш 123 сая төгрөгийн мөнгөн дэмжлэгийг манай манай жишээ нь агентлагуудаар төсөл хөтөлбөрүүдээр дамжуулж олгосон байна. 2022 онд 67 сая төгрөгийн ийм дэмжлэг олгосон байна.

Үүнтэй уялдуулаад түрүүн Л.Энх-Амгалан сайд хэлсэн. Энэ төвүүд дээр бид жишээ нь өнгөрсөн хугацаанд судалгаа хийгээд загвар төвийн ийм юу бэлэн болгосон байгаа. Тэгээд үүнийг 04 сарын 20-ны өдөр манай гурван сайдын хамтарсан төрийн бус байгууллагатай хамтарсан уулзалтууд болдог. Ээлжит. Энэ дээр танилцуулж санал авахаар

ингэж бэлдсэн байгаа гэдгийг танд дуулгая.

Хоёр дахь асуудал. Энэ мэргэжлийн боловсролын чиглэлээр нэн ялангуяа дохионы хэлний чиглэлээр хүн бэлтгэж байна уу гэж.

Ер нь яах вэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн хамгийн том бэрхшээлүүдийн нэг бол тэдгээр иргэдэд жишээ нь боловсрол олгох. Янз янзын жишээ нь мэргэжлийн чиглэлээр ажиллах ийм хүний нөөцийн дутагдал байдаг.

Үүнийг шийдвэрлэх үүднээс манай Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дэргэдэх Мэргэжлийн боловсрол, сургалт, үйлдвэрлэлийн төв дээр дохионы хэлний хэлмэрч бэлдэх ийм сургалтыг 2022 оноос эхэлсэн. Яг одоо 24 хүүхэд суралцаж байна.

Бас нэг асуудал байдаг. Дохионы хэл өөрөө янз янзаар жишээ нь дохионы хэлийг өгч байгаа ийм асуудал байгаа. Үүнийг жигдлэх чиглэлээр Боловсролын яаман дээр манайх Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам оролцсон ийм ажил давхар хийгдээд явж байгаа.

Гишүүний асуусан асуулт, Байнгын хорооны даргын асуусан асуулт хуулийн төсөл. Хоёр хуулийн төсөл байгаа. Нэг нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн тухай хууль. Үүнийг бид шинэчилсэн найруулга хэлбэрээр бэлэн болгосон. Өнөөдрийн байдлаар 7 удаагийн хэлэлцүүлгийг төрийн бус байгууллагууд, холбогдох жишээ нь төрийн байгууллагуудыг оролцуулсан байдлаар хийсэн. Бэлэн болсон байгаа.

Өмнөх хуулиасаа 50 хувиас дээш хувиар жишээ нь өөрчлөгдсөн учраас үүнийг шинэчилсэн найруулга хэлбэрээр оруулж байгаа. 13 бүлэг бүхий ийм хууль бэлэн болсон байгаа.

Хоёр дахь хууль анхдагч хууль. Энэ бол Саадгүй байдал, хүртээмжийн тухай хууль байгаа юм. Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг мөн адил төрийн бус байгууллагуудаар 5 удаа хэлэлцүүлсэн. Холбогдох төрийн байгууллагуудаар. Нэн ялангуяа жишээ нь Барилга, хот байгуулалтын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, бусад яамдаас саналыг нь авсан бэлэн болгосон байгаа.

Бид үүнийг Засгийн газарт үзэл баримтлалыг нь өргөн барихаар бэлэн болгож байна.

Г.Мөнхцэцэг: Б.Баярсайхан гишүүн тодруулах уу? Б.Баярсайхан гишүүний микрофоныг өгье.

Б.Баярсайхан: Тэгэхээр би тэр тухайн төрийн бус байгууллагад хэдэн оноос хойш хэдэн төгрөг өгсөн гэдгээсээ илүү яг өгөх ёстой юм уу, өгөх ёсгүй юм уу? Энэ асуудлыг цааш нь яаж шийдэх юм? Энэ олон хүүхдүүдийн хувь заяаг яах юм? Энэ айл, гэр бүл нь цаашдаа яаж амьдарч явах юм.

Одоо нэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айл ер нь нэг ээж юм уу, нэг аав бүтэн цагаар тэр хүмүүсийг харж байна. Тэр хүүхдийг харж байна. Туйлдаж байна. Тийм ээ. Ядарч байна, орлого багатай байна, эм тариа их хэрэглэж байна. Энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ? Ингээд нэг компани, нэг аян, нэг ийм юмаар ингээд л нэг

аргацаагаад ингээд явдаг ийм цаг үе чинь цаашаа ерөөсөө байхгүй болчихоод байна.

Тэгэхээр ер нь яг яах ёстой юм бэ гэдэг шийдэл асуусан юм.

Хоёрдугаарт, гурван яам нэгэнт ингээд ажиллаж байгаа учраас бас энэ хөгжсөн орнуудын туршлагыг судлаач. Жишээлбэл, Норвегт хөгжлийн бэрхшээлтэй хүн нь өөрөө ажил олгогч болчихдог юм байна лээ.

Г.Мөнхцэцэг: Б.Баярсайхан гишүүний минутыг нэмээд өгчихье.

Б.Баярсайхан: Тэгэхээр салбар дундын зохицуулалтыг илүү сайжруулах гэж бодлого шийдвэрээ нэгтгэж байгаа ийм үедээ илүү оновчтой ийм цаашаа бид яг яах вэ гэдэг ийм арга шийдлээ олсон ийм алсын хараатай ийм шийдлүүдийг гаргасан нь зөв байх гэж бодож байна.

Эцэст нь энэ орон нутагт хийгдэж байгаа модон жорлонгийн асуудлыг анхны тэр ажлын хэсгүүд дээр ч гэсэн бид ярьж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орох боломжтой зайтай талбайтай гээд.

Тэгээд энэ хурал дээр оролцож байгаа Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир дарга бас энэ орон нутагт хийгдэж байгаа орчин үеийн ариун цэврийн байгууламжийг мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ээлтэй байлгах тал дээр та анхаарч ажиллаарай гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Санал хэллээ. Ч.Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Түрүүн сайд хэлж байна л даа. Байгууллага дээр суурилсан

ийм тогтолцоо байсан нь буруу байжээ. Одоо бид нэгдсэн яг иргэндээ зориулсан тогтолцооны зураглал боловсруулаад явж байна гээд.

Энэ сайн хэрэг гэж бодож байна. Гэхдээ энэ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар гээд нэг агентлаг 2018 онд Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан байдаг юм байна.

Энэ байгууллага энэ зураглалыг аль 2018 ондоо, больё гэхэд 2019 онд үүнийгээ боловсруулаад гурван яам хоорондын уялдаа холбоог хангаад ажиллаж байх ёстой гэж би бодоод байна л даа.

Тэгэхээр энэ агентлаг яг юу хийдэг юм бэ? Ямар төсөв мөнгөөр үйл ажиллагаа явуулдаг юм. Хэдэн хүний бүрэлдэхүүнтэй, сүүлийн үед юу хийв? Би бүр өнөөдөр веб сайт руу нь орж үзлээ. Сүүлийн үед хийсэн ажил ерөөсөө веб сайтад нь харагдахгүй байна лээ.

Тэгэхээр энэ байгууллагыг ажиллуулах ёстой гэж би нэгдүгээрт бодоод байна.

Тэгэхээр энэ байгууллагын төлөөлөл ч юм уу, яам нь энэ дээр хариу өгөх ёстой байх гэж бодож байна.

Хоёрт нь, энэ төсөв мөнгөтэй холбоотой. 2023 онд 2.6 тэрбум төгрөг хувьсах зардалд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулж тавьсан гэж байна. Энэ яг боловсролын салбарын нийт төсөвтэй харьцуулах юм маш бага мөнгө гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ.

Тэгээд энэ нь болохоор зөвхөн хувьсах зардал гээд цаана нь энэ хүүхдүүдэд орчныг нь бүрдүүлэх шаардлагатай. Ингээд 70 орчим тэрбум төгрөг хэрэгтэй гээд ярьж байна.

Дээрээс нь, энэ сургалтын хэрэглэгдэхүүнүүд ерөөсөө хангалтгүй байна. Өнгөрсөн жил Б.Жаргалмаа гишүүн бид хоёр энэ Боловсролын тухай хуулийн 42.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаад нэлээд олон сургуулиудаар явсан.

Сургуулиудад брайлээр хийсэн ном ч байдаг юм уу, сонсдог ном, дэвтэр гээд ийм шаардлагатай хэрэглэгдэхүүнүүд ерөөсөө байхгүй. Зарим сургуульд байгаа мөртөө нөгөөдхөө ингээд шилэн хоргонд үзмэр шиг хийгээд хадгалчихсан. Тэрийг нь хэрэглүүлдэг багшийн хүрэлцээ байхгүй гэсэн ийм асуудлууд байна.

Тэгэхээр бид зөвхөн орчноос гадна нөгөө агуулга руугаа илүү анхаарах ёстой шүү дээ. Мэдээж сургууль руугаа орж гарах шаардлага байгаа. Гэхдээ ороод юм сурах гэж орж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хэрэглэгдэхүүн дээр хэрхэн анхаардаг юм бэ? Зөвхөн энэ 2.6 тэрбум төгрөг чинь ингээд хангалттай гээд өгчихдөг юм уу? Эсвэл жил болгон хэрэглэдэг энэ сурах бичгийн зардлын тэдэн хувь нь яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан ном, сурах бичигт зарцуулагдах ёстой гэж Та бүхэн тусгайлан тавьж өгдөг юм уу, үгүй юү гэдэг ийм асуулт байна.

Мөн сая хэллээ. Багш бэлтгэх тогтолцоо. 66 багш бэлтгэгдсэн. 51 нь бэлтгэгдэж байна гэж байна.

Тэгэхээр бидний энэ 21 аймаг, 9 дүүрэгт байгаа энэ хөгжлийн бэрхшээлтэй шат шатын боловсролын байгууллагад байгаа хүүхдүүдэд энэ хангалтгүй гэдгийг бид мэдэж байгаа.

Тэгэхээр зүгээр тухайн сургуульд байгаа тодорхой багш нарыг нь аваад маш хурдтайгаар ингээд сургачих тийм хөтөлбөр эд нар хэрэгжиж байгаа юу? Эсвэл байхгүй хэрэгжүүлэх боломж байна уу гэсэн асуулт байна.

Мөн энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмийн асуудлыг эцэг, эхүүд нэлээн тавиад энэ гадаа хүртэл жагсаад нэлээн юм болж байсан. Үүнтэй холбоотой ямар арга хэмжээ авагдсан бэ? Зарим шаардлагатай эм нь Монголд хориотой байдаг. Зарагддаггүй. Зарагдсан ч чанаргүй байдаг. Маш үнэтэй байдаг гээд олон асуудал ярьж байсан.

Тэгэхээр үүнтэй холбоотой ямар арга хэмжээ сүүлийн хугацаанд хийгдсэн бэ гэдгийг Эрүүл мэндийн яамнаас асуумаар байна.

Эцэст нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийн дэд сан гээд бид Хөдөлмөрийн тухай хуульд бүр ийм тусгай дэд сан байгуулья гэж хуульд тусгаж өгсөн.

Тэгэхээр 2022 онд энэ дэд санд хэдэн төгрөг хуримтлагдаад тэрийгээ юу юунд зарцуулахаар 2023 оны төсөвт төлөвлөөд оруулж ирж.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар гэж байгаа. Энэ агентлагийн дарга нь Ц.Нямсүрэн. Тийм ээ. Ямар ажил хийдэг, яадаг юм гээд ингээд асуулт

асуулаа. 2 номерын микрофон дээр хариулт авъя.

Ц.Нямсүрэн: Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын дарга Ц.Нямсүрэн Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь 2018 онд Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан. Агентлаг маань хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, нийгмийн хамгааллын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хэрэгжилтэд нь хангах, хяналт тавих, мөн орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл гээд Засаг дарга нараар ахлуулсан салбар зөвлөлүүд бий.

Эдгээрийн хоорондын уялдаа холбоог хангах, нийгэмд хөгжлийн бэрхшээлийн талаарх зөв ойлголтын талаар нөлөөллийн сургалт хийх гэсэн ийм агуулгатайгаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хуульд батлагдсан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинэчилсэн найруулгыг удахгүй өргөн барина.

Энэ дээр илүү энэ агентлагийн чиг үүргийг тодорхой болгох, нэмж шаардлагатай чиг үүргүүдийг нэмж тусгах ийм шаардлага байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын хувьд одоохондоо орон нутагт хөл гэж ярьдаг. Тийм ээ. Алба албан ёсны ажилтан байхгүй. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан гэсэн

мэргэжилтнээр дамжуулж ажлаа хийдэг учраас бас яг өөрийн гэсэн албан хаагчгүй байдаг ийм зовлон бий.

Одоогоор 33 орон тоотойгоор ингээд үйл ажиллагаагаа явуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө гээд Хөдөлмөрийн тухай хуульд орчихсон явж байгаа.

Энэ хуулийн хүрээнд жилд тодорхой хэмжээний санхүүжилт цугладаг. Өнгөрсөн жил Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулга үйлчилж эхэлсэн. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлдөг болсон учраас дэмжих санд цуглах мөнгөний хэмжээ буурсан байгаа.

Өмнө нь 11.7 тэрбум төгрөг 2021 онд цуглаж байсан бол 2022 онд буугаад 3.4 тэрбум төгрөг буурсан байгаа.

Өмнө нь болохоор Хөдөлмөрийн хуулийн шинэ хууль үйлчилж эхлэхээс өмнө тухайн байгууллагын ажилчдын дундаж цалингийн хэмжээгээр ажиллуулаагүй төлбөрийг төлдөг байсан юм.

Тэр нь статистикийн нэг сая 200 орчим байсан бол одоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 550 мянга болж буурсан учраас Дэмжих санд төвлөрөх санхүүжилт дагаад буурсан байгаа гэдгийг танд хэлье.

2023 оны хувьд Дэмжих санд цугласан мөнгөөрөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд санхүүгийн дэмжлэг олгодог байгаа.

Аймаг, дүүргээр дамжуулаад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 10 сая хүртэлх санхүүгийн дэмжлэгийг олгодог. Хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан иргэн, аж ахуйн нэгж 20-иос 30 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг дэмжлэг олгодог.

Энэ санхүүгийн дэмжлэгээр дамжуулаад жилд 2 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй хүн ажлын байртай болдог гэсэн ийм дүн гардаг.

Г.Мөнхцэцэг: Боловсролын яамтай холбоотойгоор тэр сургалтын хэрэглэл, хүүхдийн сурах бичиг, багш нартай холбоотойгоор асуулт асуусан.

Л.Энх-Амгалан сайд хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Ч.Ундрам гишүүний хөндөж тавьж байгаа асуудал үнэхээр зөв өө. Үнэхээр энэ 100 гаруй, 104 сургууль дээр бид энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих төв кабинет л юм даа. Тийм ээ. Байгаа юм.

Тэгээд хөдөө орон нутаг дээр ингээд очоод үзэхээр тэр кабинетын ашиглалт үнэхээр байхгүй. Үүнийг бид үнэнийг л хэлэх ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн кабинетын ашиглалт байтугай бид бага ангийн хүүхдүүдийн систем сургалтуудын байгалийн ухааны тоног төхөөрөмжүүдийг өгөөд энэ багш нар чинь ашиглахгүй шилэн хоргоны цана түгжээтэй л байж байгаа шүү дээ.

Тийм учраас ерөөсөө энэ боловсролын салбарт хийгдэж байгаа энэ ажлууд, энэ шинэчлэлийн ажлууд ерөөсөө сургууль дээр очоод л нурчихдаг юм байна гэж би ойлгож байгаа. Ерөөсөө

сургууль дээр очоод л нурдаг, цэцэрлэг дээр очоод нурдаг.

Тэгэхээр энэ тогтолцоог бид ер нь арилгаж байж л яахгүй бол, нэг шинэ шатад гаргахгүй бол ингээд нэг ийм зүгээр өнгөцхөн. Нөгөө дээрээс дарга ирэхээр нөгөө тоосоо арчаарай, ширээний бүртгэл гээд тавиарай гэдэг шиг нэг ийм маягаар хандаж байгаа юм. Нийтлэг ерөөсөө энэ. Яг үнэнийг хэлэхэд манай энэ сургууль, цэцэрлэгүүдийн хамт олон, сурган хүмүүжүүлэгч нар мэдээж сайн сургууль, цэцэрлэгүүд байгаа. Жишиг болохоор.

Гэхдээ нийтлэгээрээ ерөөсөө энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд яг энгийн хүүхдүүдтэй адилхан орчинд сурч боловсрох ийм эрхтэй юм шүү гэдэг энэ ойлголтуудыг л бид нийтээр нийгмээр л төрүүлэхгүй бол энэ дээр ер нь маш их тийм сэтгэл эмзэглүүлсэн. Хүүхдийн эрх зөрчигдөж байгаа. Ингээд ялгаварлан гадуурхалт байгаа гэдгийг бид хүлээн зөвшөөрөхөөс өөр арга байхгүй. Бид үнэнтэй нүүлт нүүр тулах ёстой.

Хоёрдугаар асуудал бол ерөөсөө санхүүжилт ерөөсөө л ийм шүү дээ. Ч.Ундрам гишүүн ээ. Одоо ингээд юуны сургуулийн өмнөх боловсролын түвшинд 1498 хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн түвшинд энгийн сургуулиар 5673 хүүхэд. Ингээд л үүнийг чинь бид нөгөө нэг хүүхдийн хувьсах зардлыг 3 дахин үржүүлээд сургуульд нь олгочхож байгаа юм.

Нөгөө тэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нар дээр бид 30 хувийн нэмэгдэл гэж өгдөг. Одоогийн байгаад байгаа санхүүжилтийн тогтолцоо чинь ердөө л энэ байхгүй юу.

Тэгэхээр бид нарын нөгөө энэ боловсролын багц хууль маань батлагдаад гарах юм бол нөгөө таны хөндөж тавиад байгаа тэр хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй байгаа тэр сургалтын хэрэглэгдэхүүнүүд байна шүү дээ. Тийм ээ. Тэр хэрэглэгдэхүүнүүдийг хүртэл одоо ингээд тодорхой тэр юуных нь хувьсах зардлынх нь зардалд бүтцэд нь оруулж тооцдог. Багш нарын асуудал. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарын асуудал? Хөдөлмөрийн үнэлэмжийн асуудлууд, нийгмийн баталгааны асуудлууд ч гэсэн энэ дээр нэлээн ийм шинэлэг эрх зүйн орчин бүрдэх л нэг ийм л боломжууд л харагдаад байгаа байгаа юм.

Одоо жишээ нь манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан байна. Нөгөө халамжийн хуулиар олгодог 70 нэр төрөл юм билүү. Тийм ээ. Нөгөө энэ тоног төхөөрөмжүүд байдаг юм байна лээ шүү дээ. Энэ үнэхээр хоцрогдчихсон юм байна лээ. Одоо тэр жагсаалтаас хүртэл ингээд бид яг тэр өөрсдөө хүүхэд бүрийн хөгжлийн тэр ялгаатай хэрэгцээн дээр нь суурилсан тэр жагсаалтуудыг баталж байхгүй бол техник технологи маш их хөгжиж байна.

Энэ дээр бид үндэслэж ер нь үүнийгээ ч гэсэн харах ёстой. Ер нь тэгээд товчхондоо хэлэхэд энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ энэ эцэг, эхчүүд, асран хамгаалагч нарын зүгээр энэ халамжаас авч байгаа хоёр зуун хэдэн мянган төгрөг. Энэ бол арай хэтэрхий. Энэ чинь хөөрхий насаараа нэг хүүхдийн цаана хоёр эцэг, эх зовж байгаа байхгүй юу. Энэ дээр тэр халамжийнх нь тэр мөнгийг миний болдогсон энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулаад. Тийм ээ. Ингээд нэг ийм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ чинь

550 мянган төгрөг болох гэж байгаа биз. Тийм ээ.

Тэгээд тэр хэмжээнд олгодог нэг ийм тогтолцоо хийж байж л ингээд нэг ийм жаахан өргөс авсан юм шиг тэр зовлонг хуваалцахгүй. Гэлээ гэхдээ тэр яг тэр хүүхдүүдийн цаана байгаа эцэг, эхчүүд. Тэр чинь хувь заяагаараа хохирч байгаа байхгүй юу.

Тэгээд тэр эхчүүдийг дэмжих нэг ийм бодлого л явах ёстой юм байна. Тэгээд нөгөө талаасаа нөгөө яг энэ байгууллага дээр суурилсан үйлчилгээ, тогтолцоо биш. Иргэнээ хөөсөн энэ тогтолцоо руу л бид орж байж л энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж байгаа энэ тусламж, үйлчилгээн дээр тодорхой чанарын хүртээмжийн ялгаа гарах юм байна л гэж хараад байгаа шүү дээ. Тийм ээ.

Г.Мөнхцэцэг: Тэр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн чиглэлээр эрүүл мэнд, эм, эмийн чанарын асуудлаар С.Энхболд сайд. 2 номерын микрофон дээр С.Энхболд сайдаас хариултыг авъя.

С.Энхболд: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

Эрүүл мэндийн яамны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээ, эмчилгээнд хэрэглэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн чиглэлээр гол баримталж байгаа бодлогын хувьд эмийн бүртгэлийн асуудал дээр их шуурхай хандаж байгаа.

Ялангуяа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэр дундаа уналт

таталттай хүүхдийн эм дээр нэлээн олон асуудлууд гарч ирсэн.

Бид энэ өнгөрсөн хугацаанд нийт уналт таталттай хүүхдэд хэрэглэгддэг олон улсын нэршлээр 53 нэр төрөл, худалдааны нэршлээр 93 нэрийн уналт таталтын эмийг бүртгэж импортын лицензийг олгож, ялангуяа энэ нөөцийг тасалдуулахгүй байх тал дээр онцгой анхаарч ажилласан.

Дээрээс нь, Эрүүл мэндийн даатгалын сан дээр хөнгөлөлтийг төрөөс 100 хувь даадаг болгосон байгаа. Энэ ялангуяа энэ 0-ээс 18 насны хөгжлийн бэрхшээлтэй, тэр дундаа уналт таталттай хүүхдүүдэд маш томоохон дэмжлэг болно гэж үзэж байгаа.

Мөн дээрээс нь, ялангуяа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн саажилттай хүүхдүүд байдаг. Энэ дээр бид ялангуяа тэр мэдрэлийн ёзоор таслах буюу резо томьёо хагалгааг нэвтрүүлэх ажиллагааг эхэлсэн. Энэ дээр Турк болон Япон Улс, Польш Улсын эмч нартай хамтарч энэ хагалгааг өөрийн улсдаа нэвтрүүлээд, мөн тодорхой тооны эмч нарыг сургалтад хамруулаад ингээд явж байна.

Мөн дээрээс нь, энэ эпилепси, паркинсон гээд энэ үйл ажиллагааны эмгэгтэй хүмүүст хагалгааг өөрийн орондоо хийх боломжийг бүрдүүлэх чиглэлээр хэд хэдэн ажлууд хийгдээд энэ төрлийн хагалгааг Монгол Улсад нутагшуулах зорилготой. Эхний хагалгаанууд амжилттай хийгдээд явж байгаа.

Энэ мэтчилэн ялангуяа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэр дундаа уналт таталт, энэ саажилттай

хүүхдүүд дээр Эрүүл мэндийн яамны зүгээс эмнэлгийн тусламж, үйлчилгээ дээр онцгой анхаарч ажиллаж байгаа.

Г.Мөнхцэцэг: Д.Батлут гишүүн асуултаа асууя. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүний нэрийг оруулчихъя. Нэмээд асуултад. Д.Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Би хэлэлцэж байгаа асуудалтай шууд хамааралгүй зүйлийг асууя гэж бодож байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд нийгэмд гадуурхагддаг. Мөн түүний гэр бүл ч гэсэн бас нийгмийн харилцаанд ороход хүндрэл учирдаг. Далд хэлбэрийн тийм гадуурхалт явагддаг.

Хүүхдээ харах хандахаас авхуулаад ажил хийх боломж олддоггүй. Мөн эдийн засгийн хүндрэлд ордог гээд маш их асуудлууд дагуулдаг л даа.

Тэгэхээр энэ байдлаас бид урьдчилан сэргийлэх боломжууд тодорхой хэмжээгээр байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр үүнийг би ярихын өмнө эрүүл мэндийн салбар дээр нэлээн анхаарах ёстой юм гэж. Орхон аймагт. Би улсын хэмжээний мэдээлэл алга байна. Орхон аймагт 4126 иргэн байгаагаас 29.7 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй гэдэг тийм оношлогдсон байгаа юм.

Нийтдээ нэг 390 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас 30 орчим хувь нь төрөлхийн хөгжлийн

бэрхшээлтэй хүүхэд байна гэдэг ийм онош тогтоосон байна.

Тэгэхээр шинжлэх ухаан, технологийн салбар маш сайн хөгжчихсөн энэ цаг хугацаанд бид ураг хөгжиж байх явцад оношлох боломжууд зөндөө байгаа. Нэг ёсондоо тодорхой ургийн хөгжлийн хугацаанд. Нарийн би хэлж мэдэхгүй. Нарийн технологийн тэр эхогоор харж тухайн хүүхдэд урагт ямар хөгжилтэй байгаа вэ, цаашлаад гарах эрсдэлүүд нь ямар байгаа вэ гэдгээ тодорхойлох боломжтой болсон гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр эрүүл мэндийн салбарынхнаас асууя. Ийм боломжууд манай Монгол Улсад хэр байгаа юм бэ? Техник технологийн хувьд.

Мөн дээрээс нь хүний нөөцийн хувьд боломж байгаа юу?

Монгол Улс өөрөө цөөхөн хүн амтай. Ирээдүйгээ бид хүүхдүүдээ хүн амаа өсгөх бодлого нэлээн түлхүү тавьдаг улс орон шүү дээ.

Тэгэхээр ирээдүй болсон энэ хүүхдүүдийг бид эрүүл төрүүлэх, эрүүл хүүхэд төрөх боломжуудыг анхаарч явах ёстой гэж харж байгаа юм. Энэ тал дээр цаашлаад ямар бодлого гаргаж, ямар хөрөнгө оруулалтуудыг хийж ажиллах юм бэ?

Үндсэндээ манай иргэд мэдэхгүйн зовлон маш их байгаа байхгүй юу. Бүхий л салбар дээр байгаа. Өнөөдөр төр төрөхийн өмнөх хяналтад ордог ч гэсэн нарийн эхогоор харуулж байж харуулаад тухайн ургийн хөгжлөө тодорхойлдог, янз бүрийн эрсдэл гарахаас хамгаалдаг

тэр боломжуудыг иргэн бүр төдийлөн мэдэхгүй байгаа.

Тэгэхээр бид нарт зөвхөн ганцхан энэ асуудал дээрээ ийм байгаа юм чинь эрүүл мэндийн салбарт бүхэлдээ маш олон асуудлууд байгаа. Иргэд мэдэхгүй асуудал.

Тэгэхэд Монгол Улс өнөөдөр нийгмийн эрүүл мэндийн хууль байхгүй л явж байгаа. Энэ яам, энэ Засгийн газраас энэ нийгмийн эрүүл мэндийн тухай хуулиа яаралтай оруулж ирэх ёстой гэдэг асуудлыг удаа дараа хэлж байгаа. Одоогоор алга байна.

Бид энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийг яагаад шаардаад байгаа вэ гэхээр энэ нийгмийн эрүүл мэндийн тухай хууль гарах юм бол бид иргэдээ соён гэгээрүүлэх, эрүүл мэндийн чиглэлээ соён гэгээрүүлэх олон ажлууд хийх боломжтой.

Ингэснээрээ гарч болох, тухайн иргэнд учирч болох, үзүүлж болох сөрөг нөлөөллүүдийг тодорхой хувиар, магадгүй 60, 70 хувиар бууруулах боломжтой шүү дээ.

Бид иймэрхүү арга хэмжээг авч хэрэгжүүлж чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Энэ хуулийг хэзээ оруулж ирэх юм бэ? Цаашлаад яах юм бэ нөхөд өө?

Хэрвээ ийм байдал даамжрах юм бол энэ ирээдүй болсон хүүхдүүдийн асуудал ч гэсэн хэзээ ч тасрахгүй.

Г.Мөнхцэцэг: Асуулт тодорхой. Тийм ээ. 2 номерын микрофон дээр С.Энхболд сайд хариулья.

С.Энхболд: Д.Батлут гишүүний асуултад хариулья.

Энэ бол яалт ч үгүй бас тулгараад байгаа, цогцоор нь шийдэх нэг асуудлын нэг байгаа. Энэ дээр өнгөрсөн хугацаанд бид бүхэн үе шаттай ажлуудыг хийсэн.

Ялангуяа бид энэ ураг байхад нь оношлох энэ скрийнинг буюу пренатал скрийнинг шинжилгээг нэлээн үе шаттай эмнэлгүүдэд нэвтрүүлж тодорхой хөрөнгө оруулалтуудыг үе шаттай шийдвэрлүүлж эхнээсээ байгуулагдаж байгаа.

Эхний ээлжид Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв дээр нэг байгуулагдсан байна. Дараагийнх нь энэ хоёрдугаар Хүрээ амаржих газар, нэгдүгээр төрөх буюу Өргөө амаржих газрууд дээр энэ нэг үе шаттай байгуулсан байгаа.

Энэ шинжилгээ хайхад хүний хүний нөөцийн хомсдол үүссэн. Тэгэхдээ үүнийг бид үе шаттай сургалтуудаа хийгээд боловсон хүчнээ бэлдэж байна. Эхний ээлжид бид энэ төв суурин газраа бол нэлээн үе шаттай хөгжүүлсний дараа дараагийн ээлжид энэ орон нутаг руу гарах ийм төлөвлөгөөтэйгөөр энэ хөрөнгө оруулалтууд хийгдэж, хүний нөөцөө бэлтгэж явж байгаа.

2022 оны байдлаар Эх, хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв дээр энэ удам зүйн лабораториор 4785 жирэмсэн эх хамрагдсан байгаа. Үүнээс хромосомын өвчний эрсдэл өндөртэй 335 эхийг ураг орчмын шингэнд нь шинжилгээ хийсэн. Үүнээс 52 хромосомын өөрчлөлт оношлогдсон байгаа.

Энэ мэтчилэн бид ялангуяа энэ урагт байхад нь ялангуяа энэ төрөлхийн гажгийг эрт үед нь оношлох энэ арга барил руу Эрүүл мэндийн яам бодлогоо бариад үе шаттай аргууд хийгдэж байгаа.

Тэгэхээр цааш цаашдын жил жилийн төсвүүдэд бид энэхүү удам зүйн лаборатори байгуулагдах чиглэлийн энэ хөрөнгө оруулалтуудыг илүү тусгаж явж байгаа.

Тэгэхээр ялангуяа энэ хүний нөөц бэлтгэгдээд ирэхээр энэ хүний хөрөнгө оруулалт, дэд бүтцүүдийг бэлдсэн цагт энэ орон нутгууд руу энэхүү тусламж, үйлчилгээ, оношилгоо маань нэлээн өргөжөөд явна гэж үзэж байгаа.

Г.Мөнхцэцэг: Л.Энх-Амгалан сайд өөрөөсөө асуулт асуухгүй биз дээ? Тодруулах уу? Д.Батлут гишүүн тодруулья.

Д.Батлут: Яам маань бодлогоо тодорхой болгох хэрэгтэй. Энэ наад үгийг чинь хэн ч хэлчихнэ.

Зүгээр нэг ийм нэг бүдүүн хатуу хариулт хэлэхээ больцгооё. Бүдүүн хатуу хариулт хэлж байгаа та бүхний бодлого гэдэг зөвшөөрөл нь тийм бүдүүн хатуу байна л гэсэн үг.

Тэгээд хэрэгжих боломжгүй, үр дүн өгөх боломжгүй байна гэсэн үг шүү дээ.

Бүгдээрээ гишүүд ээ, Байнгын хороодын хороодын дарга нар ч гэсэн бодолцооч 2024 оны төсөвт бүгдээрээ энэ тал дээр анхааръя. Аймаг болгондоо бид тийм нарийн судлах эхо аппарат авч хөрөнгийг нь шийдэж өгье. Хүний

нөөцийн асуудлыг нь шийдэж өгье ийм уриалгыг гаргаж байна.

Ингэж чадсанаараа бид ирээдүй болсон хүүхдүүд эрүүл төрөх боломж байна. Эрүүл хүүхэд төрж бойжих, цаашлаад Монгол Улсад хэрэгтэй хүн болгоход маш чухал алхмыг хийнэ шүү гэдгийг хэлмээр байна.

Тэгээд Эрүүл мэндийн яамныхаа бодлогоо тодорхой болгооч ээ. Та нарын хариулт чинь бөөрөнхий. Бодлого чинь ч гэсэн тэгэхээр бөөрөнхий байгаа.

Г.Мөнхцэцэг: Санал хэлье. Ё.Баатарбилэг гишүүн асуултаа асууя. Л.Энх-Амгалан гишүүн нэрээ авчихсан байна. Ё.Баатарбилэг гишүүн асуулт асууя.

Ё.Баатарбилэг: Байнгын хорооны гишүүдийнхээ амар мэндийг айлтгая. Хоёр, гурван зүйл л байна.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын нийгмийн баталгааны асуудал, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын эрүүл мэндийн асуудал гээд маш олон асуудлууд.

Өнөөдөр яах вэ, гишүүд нэлээн тодорхой асуултууд асууж байна. Сайд, холбогдох яамдын нөхдүүд маань хариулж байна.

Тэгэхээр Байнгын хорооны даргад хэлэхэд энэ боловсролын хуулиа түргэлэхгүй юм уу? Г.Мөнхцэцэг дарга аа. Одоо ажлын хэсгийн ахлагч Г.Дамдинням дарга гараад явчихлаа.

Боловсролын сайд байна. Хоёр жил шахуу улс орон даяар хэлэлцүүлэг өрнүүлж маш олон боловсролын

салбарын ажилтан, албан хаагчид, суралцагчид, эцэг, эхчүүдийн төлөөлөл оролцож, төрийн болон төрийн бус байгууллагууд оролцож нэлээд гайгүй хуулийн төсөл бэлэн болсон гэж би ойлгож байгаа. Боловсролын ерөнхий хуулийн ажлын хэсгийг би ахалж ажилласан хүний хувьд.

Тэгээд Г.Мөнхцэцэг дарга энэ минут сунгаж өгөх юм уу. Эсвэл. Тийм. Эхний ээлжинд ерөнхий боловсролын хууль энэ тэрээ явуулахгүй юм уу?

Яагаад үүнийг яриад байгаа гэхээр өнөөдөр яригдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын асуудал чинь энэ хоёр хуульд нэлээн сайн суучихсан. Одоо байгаа хууль эрх зүйн орчноо сайжруулахаар суучихсан. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сурах орчин, нөхцөл, тэд нарт сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, тэдний сурах орчинтой холбоотой стандарт юмнуудыг нь сайжруулж мөрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллаж байгаа багш, сургууль, нийгмийн ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх гээд нэлээд олон асуудлууд энэ Боловсролын хуульд суучихсан явж байгаа байгаа шүү дээ.

Тэгээд юун дээрээ гацаад байдаг юм. Энэ хуулиа түргэлмээр байна. Нэгд.

Тэгэхээр энэ дээр яах вэ, зүгээр энэ санал гээд ойлгочхоорой. Боловсролын сайд бодвол хуулиа явуулья л гэж бодож байгаа байлгүй гэж бодож байна.

Хоёрт, асуулт. Энэ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ юуны төв гээд энэ Хөдөлмөрийн яаманд байдаг. Энэ дэд сайд байх шиг байна. Энэ танай яаманд

зайлшгүй байх шаардлага байгаа юм уу? Эрүүл мэндийн яамны харьяанд байгаад танай яам яах ёстой юм уу? Үүнийг би зүгээр яг юуг нь сайн мэдэхгүй байна.

Яагаад гэхээр тэр чинь нөгөө эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаанууд явуулдаг энэ тэр гэж би ойлголт авсан юм л даа. Зүгээр тэр дээр дэд сайд тодруулга хэлээрэй.

Яагаад гэхээр энэ нөгөө салбар дундын зохицуулалттай ийм байгууллагууд байгаа. Одоо ингээд манай Боловсролын яам жишээлэхэд Эрүүл мэндийн яамтай хамааралтай гээд л дундын нэг эмнэлэгтэй ч юм уу, сургалтын эмнэлэгтэй ч гэдэг шиг ингээд нэг ийм хоёр тэр яамдын дундын ийм юмнууд байгаа болохоор энэ яамандаа байвал яадаг юм тэр яамандаа байвал яадаг юм гэдэг ийм юмнаас болоод дунд нь нөгөө байгууллага нь орхигдчих гээд байдаг.

Тэгээд зарим ажилтан, албан хаагчид нөгөө үгүй манайх уг нь Эрүүл мэндийн яаманд байвал илүү зохимжтой гээд л тэгдэг. Зарим нь эндээ байвал зүгээр байна гээд л тэгдэг.

Саяхандуу танай яамны дэргэдэх энэ байгууллагын асуудал хөндөгдөж байсан болохоор үүнийг танаас тодруулж асууж байгаа юм. Энэ дээр та нэг тодорхой тайлбар хэлээч ээ гэж ингэж тодруулж асуух гэсэн юм.

Г.Мөнхцэцэг: Ё.Баатарбилэг гишүүн ер нь боловсролын багц хуулийн тухайд ер нь саналаа хэллээ гэж ойлгож байна.

Тэгээд ер нь боловсролын багц хуульд энэ хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдийн боловсрол олгох, энэ сургуулийн орчин нөхцөлийг дээшлүүлэх тал дээр томоохон заалтууд орж дэвшил гарч байгаа гэж ингэж харж байгаа.

Тэгээд ер нь ажлын хэсэг хуралдаад саналын томъёоллуудаа ингээд хийгээд үндсэндээ ажлын хэсэг ажлаа ингээд бэлэн болгочихсон байж байгаа. Удахгүй энэ хууль явах байх гэж ингэж саналаа хэлж байгаа.

Нийгмийн хамгааллын яамтай холбоотойгоор асуулт асуусан энэ дээр дэд сайд С.Зулпхар сайд хариулт өгье.

С.Зулпхар: Ё.Баатарбилэг гишүүний асуултад хариулья.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв гэсэн ийм байгууллага байгаа юм. Энэ байгууллага өөрөө жишээ нь албан хаагч нар нь төрийн үйлчилгээний статустай ийм байгууллага. Энэ байгууллагыг анхнаасаа байгуулахдаа таны хэлсэнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн сэргээн засах үйлчилгээ үзүүлэх ийм зорилготойгоор байгуулсан ийм байгууллага юм байгаа юм.

Энэ ч үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар дундын үйл ажиллагааг зохицуулах үүднээс энэ бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд байх нь зохимжтой юм байна гэдэг үүднээс агентлаг манай дээр байгаа учраас үүнийг ингэж Засгийн газрын тогтоолоор дүрмийг нь батлаад ингээд үйл ажиллагаа явуулж байгаа.

Гэхдээ таны хэлдэг үнэн. Манай Нийгмийн бодлогын байнгын хорооны

гишүүд маань очиж ажилласан. Энэ өмнө ч гэсэн үүнтэй холбоотой асуудлууд гарч байсан. Зарим ажилтнууд нь болохоор зэрэг боловсролын чиглэлийн ажилтнууд байдаг. Зарим нь яг цэвэр эрүүл мэндийн салбарынханд байдаг.

Тэгээд бид Л.Энх-Амгалан сайдын санаачилгаар байгуулагдсан манай гурван яамны ажлын хэсэг байгаа юм. Одоо энэ ажлын хэсгийн хүрээнд бид юу гэж ойлголцсон гэхээр зэрэг хамгийн гол нь энд энэ чиглэл чиглэлээрээ ажиллаж байгаа салбарууд нь арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр цаашдаа ажлаа уялдуулья гэдэг ийм ойлголтод хүрсэн.

Эрүүл мэндийн салбарынхан нь шаардлагатай жишээ нь сургалтууд, мэргэжил дээшлүүлэх энэ сургалтуудад хамруулья. Боловсролынх нь мөн адил ингээд хамруулья.

Хоёр дахь зүйл бол цалин хөлсний бас холбоотой холбоотой зүйл гарсан. Яг одоо манай системээр цалинжихаар зэрэг цалин нь их бага байгаад байгаа учраас бид санал оруулж байгаа.

Манайх одоо энэ бүтэцтэй холбоотой цалин хөлснийх нь бодлогыг нь шинэчилж байгаа. Энэ хүрээнд боловсролынх нь хүмүүс нь боловсролын чиглэлээр тэдэнтэй дүйцүүлсэн цалин авахгүй бол тэнд хүн тогтохгүй юм байна. Бэрхшээлийг ойлгосон. Ийм байдлаар бид зохион байгуулалтын, менежментийн үйл ажиллагааг нь боловсронгуй сайжруулах ийм ажлыг хийгээд явж байгаа.

Холбогдох бид мэдээлэл, тайлбарыг Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга руу жишээ нь өнгөрсөн

долоо хоногт хүргүүлсэн байгаа. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Ё.Баатарбилэг гишүүний асуултад Л.Энх-Амгалан сайд хариулья.

Л.Энх-Амгалан: Ё.Баатарбилэг гишүүний биш ээ. Түрүүний нөгөө Ч.Ундрам гишүүний юун дээр нэг дутуу мэдээлэл өгчихсөн юм байна шүү. Үүнийг залруулахгүй бол болохгүй юм байна.

Энэ 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж байгаа. Энэ бас буруу тоо. Буруу тоо ч яах вэ. Энэ нөгөө шууд нэг хувьсах зардал, ерөнхий боловсролын сургууль дээр явж байгаа хүүхдийнхээ хувьсах зардлыг ингээд дангаар нь хэлчихсэн тоо байна.

Энэ дээр ерөнхийдөө яг хувьсах зардлаар бид 6.3 тэрбум төгрөг. Ингээд хоолны юугаар үндсэндээ ингээд тэрбум орчим төгрөг гэхээр ингээд 7.3 тэрбум.

Ингээд тусгай сургууль, цэцэрлэгүүдийн сургаж байгаа хувьсах зардал 11.9 гээд 12. Ингээд бараг үндсэндээ нэг ийм 20 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтүүд хийгдэж байгаа. Хувьсах зардал, хоолны зардал дээр ингэж хийгдэж байгаа юм байна шүү.

Түрүүний тэр 2.6 тэрбум гэдэг бол бас залруулгатай юм байна шүү гэдгийг би онцлоод нэг хэлчихье гэж бодож байна. Бас буруу ойлголт төрчхөж магадгүй.

Г.Мөнхцэцэг: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор санал хэлэх

гишүүн байна уу? Л.Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Ё.Баатарбилэг гишүүн саналаа хэлье.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр өнөөдөр энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн, суралцагчдын, иргэдийн энэ сурч боловсорч байгаатай холбоотой нийгмийн хамгааллын асуудал, эрүүл мэндийн асуудлаар Байнгын хороон дээр танилцуулга сонсож байгаа нь чухал. Цаг үеэ олсон асуудал гэж бодож байна.

Харьцангуй манай боловсролын салбар дээр яг энэ хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай холбоотой шийдвэрүүд тухайн цаг үеийнхээ шаардлагыг нийцүүлээд шийдвэрүүд гараад явж байдаг. Цаашдаа ч бас ингээд Боловсролын хуульд нэлээд чухал чухал заалтууд ороод явж байгаа.

Энэ дээр салбар нэлээн гайгүй ажиллаж байгаа гэж би ойлгодог. Эрүүл мэндийн салбар дээр энэ хөдөө орон нутагт байгаа алслагдсан багт байгаа алслагдсан сум, дүүрэг, хороонд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой нэг жаахан хүндрэлтэй асуудлууд яригдаад байдаг юм. Хөдөө орон нутагт ажиллаж байхад.

Тэгээд яах вэ цөөхөн байдаг. Хөдөө орон нутагт бүр багт гэрийнхээ асаргаанд байдаг энэ хүүхдүүд, энэ ахмад настай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хүндрэлтэй асуудлууд байгаад байх шиг байдаг юм. Энэ дээр Эрүүл мэндийн сайд тодорхой хэмжээнд Эрүүл мэндийн дэд сайд байгаа учраас, сайдаар ажиллаж байсан хүний хувьд тодорхой ойлголттой байгаа байх гэж бодож байна.

Ер нь энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, энэ түрүүний миний хэлээд байгаа энэ салбар дундын зохицуулалтын асуудал дээр л хүндрэлүүд гараад байдаг юм байна лээ.

Хууль эрх зүйн орчны тодорхой зохицуулалтууд хийх тохиргоонууд хийх асуудлууд байна уу гэж харагдаад байгаа юм. Саяын миний хэлээд байгаа одоо жишээлэхэд тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэргээн засах төв гэдэг нь Эрүүл мэндийн яам мэдээд байгаа юм шиг. Нэг талаараа Хөдөлмөрийн яам мэдээд байгаа юм шиг. Хөдөлмөрийн яаманд харьяалагдаж байгаа нийгмийн хамгааллын асуудал нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцдаг гэдгээрээ тэдний энэ яаманд харьяалагдаад байгаа боловч тусламж, үйлчилгээнийх нь асуудал нь эрүүл мэндийн л асуудал байгаад байгаа байхгүй юу.

Энэ шиг одоо энэ салбар дундын зохицуулалт яг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой салбар дундын зохицуулалт дээр хууль эрх зүйн орчны тохиргоо тохируулга юман дээр нь манай Нийгмийн бодлогын байнгын хороо нэг тийм ажлын хэсэг гаргаж юм уу, эсвэл манай энэ яамд өөрснөө Байнгын хороо руу тодорхой нэг ийм ийм хуулийн эрх зүйн зохицуулалтууд, заалтууд шаардлагатай байна.

Ийм журмуудаар ингэж зохицуулж байгаа нь ийм хуулийн заалтуудтай зөрчилдөөд байна гэдэг нэг ийм юмнуудаа санал гаргаж өгөөд тэрийг нь хууль тогтоогч нар хууль хуулийн төсөл санаачлах эрх нь Байнгын хороо, гишүүдэд байж байгаа юм чинь ингээд явах боломж байна.

Эсвэл тэртээ тэргүй энэ сайд нар өөрснөө Засгийн газар байж байгаа юм чинь Засгийн газраасаа энэ тохируулгууд оруулж ирээд хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг оруулаад явах боломж байгаа юм л даа.

Тэгэхгүй бол саяын энэ жижигхэн жижигхэн хүндрэлүүдээс болоод нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд багачууд сурч боловсрох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, нийгмийн халамж хамгааллаа авах энэ юмнууд дээр нь хүндрэлүүд гарч байгаа.

Энэ дээр яах вэ би бүр тухайлан жишээ дурдаад байх юм бол алга. Салбар болгон асуудлаа мэдэж байгаа учраас ийм нэг нэгдсэн тийм нэг ажлын хэсэг гаргаад юм уу, ямар ч байсан Нийгмийн бодлогын байнгын хороогоор дамжсан нэг тийм хууль эрх зүйн зохицуулалт тохиргоонуудаа хийгээд явбал яасан юм бэ.

Энэ дээр Байнгын хорооны дарга нэг анхааралдаа аваад сайд нар анхааралдаа аваадхаач ээ. Өнөөдөр энэ Байнгын хороон дээр гишүүдийн асуусан асуултууд дотор ч гэсэн нэлээн хөндөгдөөд байна л гэж харагдаж байна л даа. Тэгээд ийм нэг саналтай байна. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Ё.Баатарбилэг гишүүнд баярлалаа. Б.Жаргалмаа гишүүн саналаа хэлье.

Б.Жаргалмаа: Баярлалаа.

Тэгэхээр мэдээж хэрэг Байнгын хороон дээр гурван яамны төлөөлөл суугаад Боловсролын сайд боловсролын салбарт хийгдэж байгаа ажлаа тайлагнаж байгаа явдал бол мэдээж хэрэг яг энэ

салбарт бид юу хийж байгаа юм, юу хийх шаардлагатай байгаа юм бэ гэдэг дүгнэлтээ гаргаж байгаа байх гэж би бодож байна.

Тэгээд ер нь хэд хэдэн асуудал байгаа. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв” дээр очоод ажиллахаар тэр статусын асуудал яг таны саяын хэлж байгаагаар үнэхээр хоёрдугаар шатлалын эмнэлэг юм уу, төрийн өмчит үйлдвэрийн газар юм уу бас мэдэгдэхгүй. Үүнээс шалтгаалаад ажилчдынх нь цалин тогтвортой бус, ажиллах боловсон хүчин байдаггүй. Алс хол байрлаж байгаа хөдөөгөөс ирж байгаа үйлчлүүлэгчид нь өдрийн хоолоо аваад идчих тийм боломж байхгүй. Үйлчилгээ авч байгаа нөгөөдөх үйлчилгээ үзүүлснээрээ бид санхүүжилтээ авч байгаа энэ цаг мөчид удаан хугацаагаар эмчилгээ авдаг хөгжлийн бэрхшээлтэй ийн энэ онцлогт тохируулсан даатгалын үйлчилгээ нь тодорхой бус.

Мөн нөгөө протез, ортопедийн үйлдвэр Монголд уг нь ганцхан байсан. Тэр протез, ортопедийнхээ үйлдвэрийн барилгыг нь бид авчихсан. Одоогийн подвалд ажиллаж байгаа.

Энэ бүхэн дээр асуудлууд шийдвэрлэх маш олон зүйлүүд байгаа.

Үнэхээр яг эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлээд байна уу, халамжийн үйлчилгээг үзүүлээд байна уу гээд үзэхээр аль аль үйлчилгээг нь үзүүлж байгаа учраас гурван яам гурвуулаа хамтран ажиллах зайлшгүй шаардлага байгаа.

Бас нэг хүндрэлтэй асуудал энд нэг зүйл байна. Асрамж, халамжийн төвд

байгаа 86 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас 17 хүн насанд хүрсэн буюу 18-аас 38 насны ийм хүмүүс байгаад байгаа юм.

Яг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв” дээр гэхэд 20 настай н.Хулан гээд нэг охин байгаа. Тийм ээ. Тэр хүмүүс хаачуулахаа бид мэддэггүй. Батсүмбэр лүү явуулах гэхээр нөгөө ахмад настан гэдгээр тийшээ очих боломжгүй.

Тэгэхээр энэ асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага үүсчээд байгаа юм. Үүгээр бид яах ёстой юм. Энэ дээр бид бас нэгэнт Нийгмийн бодлогын байнгын хороо, Боловсролын байнгын хороо хамтарсан хурал гаргаж байгаа юм чинь Засгийн газартаа чиглэл өгөх ажлаа бид нар бас тийм ээ, тодорхой хэмжээнд үүрэгжүүлэх ёстой юм уу. Энэ дээр бас тодотгох асуудал байгаа гэдгийг хэлье.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг харах, хүүхэд харах үйлчилгээнд хамруулж байгаа юм байна. Өөрөөр хэлэх юм 2023 оны эхний улиралд нийтдээ 142 хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулж байгаа. Ирэх жил 300 хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулна гэсэн ийм тоон мэдээлэл байна л даа. Ингэснээрээ нөгөө эцэг, эхчүүдийг ажилтай болгох ийм боломжийг хангаж өгч байгаа.

Тэгэхээр энэ тал дээр бид хүүхэд харах үйлчилгээний мөнгө хаачсан бэ гэдэг иргэдийн олон асуултад Боловсролын сайд тодорхой хэмжээнд хариулт өгчих болов уу гэж бодож байна.

Өөрөөр хэлэх юм бол хүүхэд харах үйлчилгээний 2 тэрбум төгрөг

хаачсан бэ гэдэг асуулт байдаг. Тэгвэл энэ чиглэлд зарцуулсан юм байна гэдэг мэдээллийг өгчихвөл олон нийт нэг зөв мэдээллийг авчих болов уу гэж бодож байна.

Ингээд мэдээлэл өгсөн Л.Энх-Амгалан сайддаа баярлалаа.

Мэдээж Эрүүл мэндийн яам Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хууль эрх зүйн зохицуулалтыг хийж байна гэдэг, хуулийн төсөл боловсруулж байна гэдэг судалгааны ажил явагдаж байна гэдэг ийм зүйл ярьж байгаа.

Хуулийг бас бид яаравчлуулахгүй нөгөө ирэх оны төсөвтөө бид нар оруулж чадахгүй шүү гэдгийг бас дахин онцгойлон хэлье. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Б.Жаргалмаа гишүүнд баярлалаа. Л.Энх-Амгалан сайд саналаа хэлье.

Л.Энх-Амгалан: Юун түрүүн хоёр Байнгын хороо хамтарч хуралдаж яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хамрагдалтын талаар бас ингээд ийм тодорхой мэдээллүүд, дэлгэрэнгүй мэдээллүүд сонсож, өнөөгийн байгаа байдал, цаашид авч хэлэлцүүлэх чиглэлийн талаар Улсын Их Хурлын гишүүд маань тодорхой саналууд, бодитой саналууд илэрхий үндсэндээ их таатай байна.

Ерөнхийдөө яах вэ бид нарын өнөөдрийн хийж байгаа энэ хэлэлцүүлгүүд, өнөөдрийн мэдээллүүд ингээд өнгөрсөн хугацаанд гурван яамны хамтарсан түвшинд зохион байгуулж байгаа сар бүрийн хэлэлцүүлгүүдээс тодорхой үр дүн гарч байгаа гэдгийг бүх

гишүүд ерөнхийдөө ойлголт нэгтэй боллоо гэж бодож байна.

Тэгэхээр хуучин Эрүүл мэндийн яам эрүүл мэндийнхээ чиглэлээр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам халамжийнхаа чиглэлээр, Боловсролын яам боловсролынхоо чиглэлээр ингээд ийм уялдаа холбоо жаахан сул байсан.

Ямар ч байсан одоогийн шатад энэ салбар дундын уялдаа холбоо нэлээн шинэ шатад гарах ийм бололцоо байгаа юм болов уу гэж харж байна.

Тэгээд бид нарын өнгөрсөн жил, өнгөрсөн хугацаанд явж ирсэн бид нарын сул тал нөгөө байгууллагад суурилсан ийм үйлчилгээг л бид үзүүлж ирсэн юм байна.

Тийм учраас энэ тогтолцооны шинэчлэлүүдээ хийж илүү иргэнд хүрдэг ийм иргэндээ очиж үйлчлүүлдэг энэ тогтолцооны үйлчилгээнд суурилсан ийм үйлчилгээг л бид бий болгох ёстой зайлшгүй шаардлага байгаа юм.

Тэгээд энэ хүрээнд бид энэ эрх зүйн шинэчлэлийн асуудлууд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах орчныг сайжруулах асуудлууд, багш, хүний нөөц. Энэ хүний нөөц дотор яг энэ хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхчүүд асран хамгаалагч нарыг илүү их тийм давтан сургалтаар хангах, дэмжих төвүүд дээр ажиллуулах, цаашдаа өөрсдөө ажил олгогч ажлын байр бий болгодог энэ чиглэл рүү төрийн бодлого, хүний нөөцийн бодлогууд нэлээн явах ёстой юм байна.

Энэ чиглэл рүү манай яам тодорхой алхмуудыг хийж энэ сэтгэл засалч, хөдөлгөөн засалч, хэл засалч гээд

энэ бүх засалчуудын шаардлагатай хөгжлийн энэ ялгаатай хэрэгцээн дээр шаардлагатай байгаа засдаг, тусалдаг, дэмждэг, асардаг, сувилдаг, энэ чиглэл рүү энэ хүмүүсийг сургах, энэ хүмүүст энэ хөдөлмөр эрхлэх энэ боломжуудыг олгох ийм зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа.

Тэгээд мэдээж гол зүйл бол санхүүжилтийн тогтолцооны асуудал байгаа.

Тийм учраас Эрүүл мэндийн яам ч гэсэн энэ чиглэл рүүгээ сууж байгаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч гэсэн энэ чиглэл рүүгээ сууж байгаа. Манайх ч гэсэн одоо яг энэ боловсрол дээр зарж байгаа. Яг бид нарын нөгөө нэг хүүхдийг сурах хувьсах зардлуудынхаа энэ итгэлцүүр, аргачлал, бүтцүүдийг өөрчлөх ийм зайлшгүй шаардлага үүссэн учраас энэ чиглэл рүү бид энэ өөрчлөлтүүдээ хийгээд явах ёстой гэж ойлгож байгаа юм.

Тэгээд эцэст нь яах вэ хэлэхэд Байнгын хороон даргаа хоёр Байнгын хороон дарга хамтарч хуралдаж байна.

Тэгээд энэ боловсролынхоо ядахдаа боловсролынхоо энэ ерөнхий хуулийг нэг хоногийн өмнө ч гэсэн батлаад өгөөч ээ. Үнэхээр л энэ хөгжлийн бэрхшээлтэй 11 мянга 800 хүүхдийн төлөө бүгдээрээ л санаа зовж байгаа. Бүгдээрээ л сэтгэл тавьж байгаа гэж ойлгож байгаа.

Үүнийгээ бид үйлдлээрээ үзүүлмээр байна. Одоо хангалттай их хурал хийлээ. Байнгын хороон дарга аа. Хангалттай их зовлон сонслоо. Хангалттай их хууль баталлаа. Хангалттай их журам баталлаа.

Тэгээд энэ улсууд чинь гадуурхагдсан хэвээрээ, эрх нь зөрчигдсөн хэвээрээ л байгаад байна шүү дээ. Тэгээд одоо бид нар чинь ийм бодитой ийм алхмууд, бодитой шийдвэрүүд ард түмэн нэхэж байгаа шүү дээ.

Тэгэхээр яг энэ чиглэл рүү ингээд энэ боловсролын ерөнхий хуулиудаа ингээд батлах юм бол илүү өнөөдрийн энэ яриад байгаа энэ хэлэлцүүлгээр хөндөгдөөд тавигдаад байгаа энэ асуудлууд чинь шийдэх гарцууд нь угаасаа энд байгаад байгаа шүү дээ.

Нэр томьёоноосоо авхуулаад, бүтэц бүрэлдэхүүнээсээ авхуулаад, санхүүжилтүүдээсээ авхуулаад.

Энэ дээр энэ хоёр Байнгын хороон дарга би улс төрийн бүр манлайлал үзүүлж ажиллах ёстой. Ирэх долоо хоног гэхэд энэ Байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганаар энэ Боловсролын ерөнхий хуулийн хэлэлцүүлгүүд эхлэх ёстой гэдгийг өнөөдөр ингээд энэ 11 мянга 800 хүүхдүүд, үүний цаана байгаа 30 мянган эцэг, эхчүүд, асран хамгаалагч нар одоо нүдээ хөхөртөл, нүдээ чилтэл хараад сууж байгаа гэдгийг л бид ойлгомоор байна. Одоо дахиад нэг ийм олон хурал, дахиад нэг ийм олон хэлэлцүүлгээс бид ч залхаж байна, ард түмэн ч залхаж байна.

Тэгээд бодитой л нэг алхам, бодитой шийдвэрийг л гаргая.

Г.Мөнхцэцэг: Өнөөдрийн Байнгын хорооны хамтарсан хуралдаанд идэвхтэй оролцож, үнэтэй санал, үгээ хэлсэн гишүүдээ талархлаа. Мөн ажлын дэд хэсгийнхэнд баярлаж байна.

Тэгээд өнөөдрийн Байнгын хорооны хамтарсан хуралдаанаас тодорхой хэмжээгээр үр дүнтэй гарсан шийдвэрүүд гарах ёстой.

Тийм учраас энэ дээр яам хоорондын энэ уялдаа холбоо, ялангуяа энэ хууль эрх зүйн зохицуулалтуудыг хийх, ялангуяа тэр Нийгмийн хамгааллын яаман дээр байж байгаа тэр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хоёр хууль байгаа гэсэн. Энэ хуулиа яаравчилж оруулж ирэх тал дээр.

Мөн Эрүүл мэндийн яаманд тэр байгаа Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль гэж. Энэ манайд ийм хууль өмнө нь байгаагүй байх. Энэ хууль бичигдэж байгаа, явж байгаа гэсэн.

Энэ хуулийг чанаржуулж оруулж ирэх яаралтай ийм нэн шаардлагатай байгаа гэдгийг гишүүд маань хэллээ.

Дээр нь манай энэ Байнгын хороотой холбоотойгоор Боловсролын яам Боловсролын багц хуулийг хоёр жил хэртэй ярьсан. Зөндөө олон удаа бид ажлын хэсэг хуралдсан.

Ер нь шийдвэрлэх түвшиндээ очсон. Ажлын хэсэг хэчнээн ч удаа хуралдав. Тийм ээ. Ажлын дэд хэсэг бол одоо үндсэндээ ажлаа хийгээд ингээд багцлаад ороод ирсэн байж байгаа.

Тэгээд ер нь даргын зэрэг зөвлөл дээр хуваарь тавигдах юм бол Байнгын хороо хэлэлцээд явах бүх орчин нөхцөл, бололцоо нь бүрдсэн байж байгаа. Ийм учраас энэ хууль удахгүй хэлэлцэгдээд явах байх.

Ийм учраас манай Боловсролын сайд маргааш чуулган дээр энэ үгээ бас сайн хэлээрэй гэж ингэж хэлэх байна.

Ингээд манай Байнгын хорооноос Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль явж байгаатай холбогдуулаад, мөн боловсролын салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын нөхцөл байдалтай холбоотойгоор, сурах орчин, суралцах нөхцөл байдлуудтай холбоотойгоор ажлын хэсэг гараад ингээд ажиллаж

байгаа. Ч.Ундрам гишүүнээр ахлуулаад ажиллаж байгаа.

Тэгээд энэ ажлын хэсэг дорвитой сайн ажиллах шаардлагатай байна.

Ингээд энэ чиглэлүүдийг өнөөдөр энэ Байнгын хорооны хуралдаан хамтарч хийсний эцэст нь дүгнэж хэлье. Тэгээд ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон Та бүхэнд баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаан 01 цаг 53 минут үргэлжилж, 17 цаг 43 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД